

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ЕРӨНХИЙЛӨ
ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН**

Булган аймаг

№	Шийдвэрийн огноо, дугаар, тавч утга	Зүйл, заалтын дугаар, агуулга
<i>Нэг.Улсын Их Хурлын п</i>		
1	Монгол улсын эдийн Засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай 2008.11.21 Дугаар 36	2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллгааны хөтөлбөр, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хууль болон бодогын бусад баримт бичиг хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг МУ-ын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох бусадбайгууллагын удирдлагад даалгасугай.
<i>Хоёр.Ерөнхийлөгчийн</i>		
<i>Гурав.ҮАБЗ-ийн зөвл</i>		
<i>Дөрөв.Монгол улсын Засгийн г</i>		
1	Хөтөлбөр батлах тухай 1998.06.23. Дугаар 103.	3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2	<p>Журам батлах тухай 1998.07.22. Дугаар 125.</p>	<p>3. Ойн санг зохих журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх замаар түүний нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт</p>
3	<p>“Журам батлах тухай” 1998.08.19. Дугаар 149.</p>	<p>2. Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг холбогдох газрууд, аймаг, нийслэлийн Засаг даргад үүрэг болгосугай.</p>
4	<p>Усны үндэсний хөтөл бөрийг хэрэгжүүлэх тухай 1999.03.10. Дугаар 43.</p>	<p>3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоодын эх үүсвэрээс шаардагдах хөрөнгийг 1999 оноос эхлэн жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>

5	Бангkokын тунхаглалыг хүлээн зөвшөөрөх тухай 1999.04.21. Дугаар 62.	2. “Хүүхдийн сайн сайхны төлөө” Бангkokын тунхаглалд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
6	Хөтөлбөр батлах тухай /Малын эрүүл мэнд/ 1999.04.21. Дугаар 64.	2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хөтөлбөрийн зөвлөлд тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
7	Махны экспорт төслийн тухай 1999.06.23. Дугаар 101.	4. Аймгуудын махны нөөцийг зохистой ашиглах зорилгоор суурин болон нүүдлийн бага хүчин чадалтай мах боловсруулах үйлдвэр байгуулан ажиллуулах талаар гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, малын зах, мал бордох талбайг засаж тохижуулах, шинээр барих, лабораторийн баазыг бэхжүүлэх зэргээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх

8	“Хөтөлбөр батлах тухай” 1999.09.15. Дугаар 147.	2. Сум, суурин газрын дулаан хангамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламжийг ашиглах замаар шийдвэрлэх
9	Хуулийг биелэлтийг зохион байгуулж хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2000.01.21. Дугаар 10.	4. а/ Хөдөлмөрийн тухай хуулийн үзлэг, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн хамт аливаа хуулийн биелэлтийг байнгын ажил болгон Засгийн газрын нэрийн өмнөөс зохион байгуулж байсугай. б/ Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөдөлмөрийн тухай хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хамтын гэрээ хэлэлцээрийг байгуулах бүртгэх асуудлыг тодорхой ажилтанд албан ёсоор хариуцуулан гүйцэтгүүлсүгэй.
10	Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээ-ний тухай 2000.06.21. Дугаар 94.	3. Цагдаагийн алба хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл, бололцоог сайжруулах, уналга, холбоо, техник хэрэгслээр хангах арга хэмжээг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байх

11	Иргэний хамгаалалтын удирдлага, хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2000.07.05 Дугаар 111.	5-ийн “в” Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөл гарсан үед голомтыг яаралтай устгах бэлтгэлийг хангах, иргэний хамгаалалтын хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ авч ажилласугай.
12	Кассын машин ашиглах журам батлах тухай 2001.01.24. Дугаар 14.	3. Нутаг дэвсгэр дээрээ бэлэн мөнгөөр худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг 2001 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн кассын машин ашиглах журамд шилжүүлэх, тэдгээрийг хамруулах хүрээ ээлж дарааллыг тогтоож, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллах
13	Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2001.02.20. Дугаар 37.	Б. Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд орон нутгийн байгаль орчны албадыг хамруулан, тэдгээрийн материаллаг бааз, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлсүгэй.
14	Хөтөлбөр батлах тухай /мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр/ 2001.03.13. Дугаар 47.	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ, зардлыг 2001 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байх
	“Ой хээрийг түймрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2001.04.25. Дугаар 98.	7.а/ Хуурайшилт бүхий газар нутгийн түймрийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор жил бүр гаргаж, түймэртэй тэмцэхэд шаардагдах зардлыг бодитойгоор тогтоон санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэж байсугай.

15		<p>Б/ Орон нутгийн байгууллага, цэргийн дүйцүүлэх алба хаагчид, иргэдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулсны үндсэн дээр тэдгээрийг ой хээрийг түймрээс хамгаалах, гарсан түймрийг унтраах ажилд зохион байгуулалттайгаар дайчлан оролцуулж байсугай.</p> <p>В/ Ой хээрийн түймрийг унтраах техник, хэрэгсэл бүхий “мэргэжсэн баг”-ийг цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг түшиглүүлэн байгуулж, сургаж бэлтгэх, хуурайшилтын үед тэднийг түймэр гарах магадлал ихтэй нутаг дэвсгэрт байнга ажиллуулах арга хэмжээ авч байсугай.</p> <p>Г/ “Мэргэжсэн баг”-ийн хүчээр ойд цэвэрлэгээ хийж түймрээс хамгаалах зурвас байгуулах, малчдын өвөлжөө, хаваржааг түймрийн хамгаалалтын зурвастай болгох, үнс нурмаа галын аюулгүйгээр хадгалах, хаях, түймрийн аюулын үед амь нас, эд хөрөнгөө хамгаалах арга ажиллагаанд иргэдийг сургах арга хэмжээ авах.</p> <p>Д/ Түймрийн аюултай үед хуурайшилт бүхий газар нутагт аялал, зугаалга хийх, ан агнах, бугын эвэр түүх, мод бэлтгэх, байгалийн дагалт баялаг ашиглах зэрэгт оролцох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн үйл ажиллагаанд сум, багийн Засаг дарга нарын зүгээс тавих хяналт, урьдчилан сэрэмжлүүлэх ажлыг хэвшүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажилласугай.</p>
16	Хөтөлбөр батлах тухай 2001.04.29. Дугаар 114.	“Арьс шир” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг жил бүрийн 3-р сард багтаан Засгийн газарт тайлагнаж байх

17	Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2001.05.27. Дугаар 137. /ХЭАлба/	4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс 2001 оны сүүлийн хагас жилд олгох хөрөнгийн хэмжээ, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албаны зардлыг орон нутгийн төсөвт тодотгон тусгаж цаашид жил бүрийн төсөвт тусган ИТХ-аар батлуулж байхыг
18	Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2001.07.04 Дугаар 157.	<p>2. Сумын хөгжлийн сангийн зээлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийг хянан шалгаруулах, зээл олгох, хяналт тавих, буцаан төлүүлэх үйл ажиллагааг аймгуудын Засаг даргын Тамгын газарт хариуцуулсугай.</p> <p>3.Сумын хөгжлийн санд олгох хөрөнгийг 2001 оноос эхлэн орон нутгийн татааст нэмж тусгаж байхыг СЭЗ-ийн сайдад, аймгийн төсвөөс сумын хөгжлийн санд хувиарласан зээлийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн буцаан төлөлтийн мэдээг улирал, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгайлан гаргаж байхыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.</p>
19	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай 2001.11.03. Дугаар 256.	<p>б.а Хог хаягдлыг төрөлжүүлэн ялгах, тээвэрлэн зайлуулах, заагдсан цэгт хаях, цэвэр орчинд амьдрах ач холбогдол, эрүүл ахуйн шаардлагыг нийтэд ойлгуулах, сургалт, сурталчилгааг байнга явуулан, хүн амын насны онцлогт тохирсон сурталчилгааны материал, гарын авлага болон шаардагдах арга зүйгээр хангах арга хэмжээ авч байхыг Засаг дарга нарт.</p> <p>Б/ Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааны техник, технологийг 3-4 жилд багтаан шинэчлэх, дэвшилтэт менежментийг бий болгох арга хэмжээ авсугай.</p>

		В/ Хог хаягдлын хураамжийн зарцуулалтын тогтолцоог зах зээлийн нөхцөлтэй уялдуулан боловсронгуй болгох, нэгдсэн хяналтанд оруулах арга хэмжээ авсугай.
20	Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2002.01.08. Дугаар 03.	<p>4. ААН, байгууллага, иргэдийн хураан авсан ургац, өрхийн аж ахуйн газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээг статистик мэдээнд хамруулах талаар 2002 оноос эхлэн бодлого гарган ажиллахыг ҮСГ-т зөвлөж, Аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>5. Газар тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн эрсдэлээс хамгалах зорилгоор даатгалд хамруулах арга хэмжээ авч ажиллах</p>
21	“Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай” 2002.01.25. Дугаар 14.	7. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн зорилт үйл ажиллагааг эрхэлсэн ажлын хүрээ, нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, гүйцэтгэлийг жил бүрийн 1-р сард тайлагнаж байх

22	Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын дүнгийн тухай 2002.02.08. Дугаар 22.	1. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн хүрээнд олсон ололтоо эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах
23	Журам батлах тухай 2002.02.27. Дугаар 31.	2. Нийтийг хамарсан ажлыг дээрх журмын дагуу зохион байгуулж байх
24	Хөтөлбөр батлах тухай 2002.04.03. Дугаар 58.	4. "Орон сууц" үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
25	Хөтөлбөр батлах тухай 2002.05.15. Дугаар 92. /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих/	3. Хөтөлбөрийг өөрийн эрхлэх ажлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай

26	Хөтөлбөр батлах тухай 2002.05.29. Дугаар 105.	2. "Монгол орны ховор ургамлыг хамгаалах зохистой ашиглах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг аймгийн Засаг даргад даалгасугай.
27	Журам батлах тухай 2002.07.03. Дугаар 135.	2. Хандивлагч орнуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх, төвлөрсөн болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрийг ашиглах замаар аюултай хог хаягдлыг устгах, байгууламж байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх
28	Хөтөлбөр батлах тухай 2002.07.03. Дугаар 137. /Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр/	3.Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг эрхэлсэн асуудлын хүрээнд зохион байгуулан ажиллахыг
29	Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2002.09.04. Дугаар 177.	2. Орон нутгийн чанартай авто зам болон аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын автозам, замын байгууламж, талбайгаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах цэгийн байрлал, төлбөрийн хэмжээг тогтоохдоо авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний дагуу баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
30	Журам батлах тухай 2002.11.13. Дугаар 230.	2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тайван цагийн сургалтыг зохион байгуулах бэлтгэлийг энэ тогтоолоор баталсан журам, харилцан тохиролцсон нөхцөл, хуваарийн дагуу хангах арга хэмжээ авч байх
31	Хөтөлбөр батлах тухай /Рашаан сувилал/ 2002.12.13 Дугаар 251.	3. Хөтөлбөрийн үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх 2010 он. /Рашаан сувилал/

32	Эрүүл мэндийн технологийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай. 2002.12.25. Дугаар 264.	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажилла гааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардаг дах хөрөнгийг 2003 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, тодорхой хэсгийг гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллах
33	Архинд донтох өвчнийг эдгэрүүлэх чиглэлээр ажилаж байгаа зарим төрийн бус байгууллагыг дэмжих тухай 2003.04.02. Дугаар 83.	1.Архинд донтох өвчтөнийг эдгэрүүлэх “Миннесота” загварын эмчилгээний аргыг үр дүнтэй хэрэглэж байгаа “”АА төв”, “Архидалт,мансуурлын эсрэг ассоциаци” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан сургалт, суртчилгааны зардлаар хангах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, цуглаан хийх байраар тухай бүр хангаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
34	Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэм-жүүлэх талаар авах зарим арга хэм-жээний тухай 2003.06.04. Дугаар 138	5. Тэнэмэл амьдралтай иргэдийг ажлын байраар хангах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар Улаанбаатар хотын захирагчын дэргэдэх Ус суваг ашиглалтын газар, “Дэвшил трейд” ХХК зэрэг байгууллагаас гаргасан санаачлагыг дэмжиж, цаашид энэ талаар хөдөлгөөн өрнүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
35	Төрийн бус байгууллагаар үүрэг гүйцэтгүүлэх тухай 2003.07.15. Дугаар 174.	2. Байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах үүргийг гүйцэтгэж байгаа консорциумын үйл ажиллагаанд зохих хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, холбогдох шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

36	Хоршоог хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2003.10.01. Дугаар 220.	2. Хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж байхыг ХХАА-н сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
37	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2003.10.14. Дугаар 222	4.1. Энэхүү тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд бүрэн хамруулж, дүнг Стандартчилал, хэмжил зүйн төвд улирал бүр мэдээлж байх арга хэмжээ авсугай.
38	Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай 2003.11.10. Дугаар 233.	4. Төрийн үйлчилгээний зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажилчдын цалин, бусад зардлыг батлагдсан төсөвт хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зардалд шилжүүлэн тайлан болон нягтлан бодох бүртгэлд тусгаж байхыг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй.
39	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай 2003.11.12. Дугаар 241.	4. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний ажлын бэлтгэлийг ханган аймаг, нийслэл, сум, дүүрэг болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссыг тус бүр томилон ажиллуулж, бүртгэл, тооллого, үнэлгээний ажлын дүнгийн тухай тайлан, мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр болон аймаг, нийслэлээр нэгтгэн жил бүрийн 2-р сард багтаан Улсын комисст ирүүлэхийг сайд, агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

		5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний жил бүрийн дүн мэдээгээр төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн санг бүрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
40	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2004.02.11. Дугаар 35.	5. Баригдсан барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлж паспортжуулах ажлыг 2004-2005 онд багтаан дуусгаж газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн шаардлага хангаагүй орон сууц болон бусад барилгын талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
41	“Усны шинэтгэл-XXI” үйл ажиллагааны чиглэл батлах тухай 2004.03.03. Дугаар 57.	3. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ тогтоолоор баталсан үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд нутаг дэвсгэртээ хур тунадас, үерийн ус хуримтлуулах далан, цөөрөм, хиймэл нуур байгуулах ажлыг нутгийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.
42	Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах арга хэмжээний тухай 2004.04.14. Дугаар 87.	2. Тусгай хамгаалалттайгаас бусад алтны орд бүхий газарт хууль бусаар алт олборлож буй зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.
		5. Уул уурхайн орд, ашигт малтмалын нөөц бүхий бүс нутагт оршин сууж байгаа ард иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу ашигт малтмалын олборлолт явуулах талаар төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

43	Хамгаалалтын бүс тогтоох тухай 2004.05.26. Дугаар 126.	2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглох арга хэмжээ авахыг дээрх аймгуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай. /Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт оршдог Хөгнө тарнийн дээд, доод хийдийн туурийн хамгаалалтын бүсийг 42,9 га газар байхаар тогтоож/
44	Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2004.05.26. Дугаар 143.	6. Бизнес эрхлэгчдийн саналыг төрийн бодлогод тусгуулах, төр, засгийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар тухайн нутаг дэвсгэрийнхээ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын салбартай хамтран ажиллах механизмыг 2004 оны 9-р сарын 1-ний дотор бий болгон ажиллуулахыг Засаг дарга нарт даалгасугай.
45	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2004.07.07. Дугаар 150.	1. Улсын үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг Засаг дарга нарт үүрэг болгосугай.

46	“Ногоон хувьсгал” /II үе шат 2005-2012/ хөтөлбөр батлах тухай 2004.08.05. Дугаар 169.	2. Дээрх хөтөлбөрийг өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.
47	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай 2004.12.22. Дугаар 244.	3. Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /I 2004-2008/, /II 2009-2012//
48	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг батлах тухай 2005.01.05. Дугаар 02.	3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн дүрмийг орон нутгийнхаа онцлогт тохируулан батлан мөрдүүлэх, цаашид үйл ажиллагааг нь тогмолжуулахад анхаарч ажиллахыг зөвлөсүгэй
49	Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журам батлах тухай 2005.01.25. Дугаар 16.	2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд, сум, хороодод ажиллах орон тооны бус зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.
50	“Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөр батлах тухай 2005.03.09. Дугаар 43.	3.“Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөрийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

<p>3. Холбогдох аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь: 3.а. “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ойн санг нэмэгдүүлэх, ойг нөхөн сэргээх, хамгаалах, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах арга хэмжээний санхүүжилтэд хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн болон төсвийн хөрөнгийг ашиглах арга хэмжээ авсугай.</p>
<p>Бүх шатны Засаг дарга нарт: 6.а.“Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд нутгийн иргэдийг өргөнөөр татан оролцуулсугай</p>
<p>6.б.Малын хашаа хороо барихад чулуу, шавар зэрэг орон нутгийн түгээмэл тархацтай материалыг өргөн ашиглах, малын нөмөр хаалтад зориулан харгана, сөөг, бусад модлог ургамал тарьж хэрэглэх аргыг нэвтрүүлэх үндсэн дээр мод, шургаагийг хашаа хороонд зориулан бэлтгэх ажлыг зогсоох арга хэмжээ авсугай</p>
<p>6.в.Бэлчээрийг хуваарьтай, ээлж дараатай ашиглах замаар байгалийг өөрийн аясаар нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авч байсугай</p>

Үндэсний хөтөлбөр,
түүнийг хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай
2005.03.09.
Дугаар 44.

7.Говь, хээрийн бүсэд шахмал түлшний үйлдвэрлэл, эрчим хүчний бусад эх үүсвэрийг ойрын үед шийдвэрлэх чиглэлээр төсөл боловсруулан хэрэгжүүлэх, хот, төв суурин газрын түлшний модны хэрэглээг багасгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн даалгасугай

Бүх шатны Засаг дарга нарт:

9.а.Аж ахуйн нэгж, байгууллага, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, төрийн бус байгууллага, нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг, оюутан, сурагч, иргэд, хамтлагт “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой газар нутгийг хариуцуулан ажиллуулахын зэрэгцээгээр энэ ажилд оролцох гадаад орон, олон улсын байгууллагын үүсгэл санаачлагад идэвхтэй дэмжлэг үзүүлж ажилласугай

9.б.Гадаад, дотоодын албан ёсны томоохон арга хэмжээ, бүх шатны сургуулийн элсэлт, төгсөлт, цэрэг таталт, халалт, иргэдийн хуримын болон андгай өргөх ёслол зэрэг арга хэмжээний үед хот, төв суурийн газарт мод тарих уламжлалыг 2005 оноос эхлэн хэвшүүлсүгэй

		<p>9.в."Ногоон хэрэм" хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ойжуулалтын ажилд цэргийн дүйцүүлэх алба хаагчид, хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг өргөнөөр татан оролцуулсугай</p>
		<p>11.Нийслэл болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудад үр, тарьц, суулгац борлуулах, байгаль орчны мэдээлэл өгөх төвүүд бий болгох арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай</p>
52	<p>"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр" батлах тухай 2005.04.01. Дугаар 64.</p>	<p>2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн засаг дарга нарт даалгасугай.</p>
		<p>1.б.Иргэдээс амаар, бичгээр болон цахим сүлжээ, радио, телевизээр явуулж байгаа шууд нэвтрүүлгээр, түүнчлэн тусгай ажиллуулсан утсаар дамжуулан ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгах, шийдвэрлэлтийн явцыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд зарлан сурталчлах зэрэг ажлыг дээрх журамд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай</p>

53	Иргэдийн өргөдөл, гомлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 2005.04.01. Дугаар 67.	<p>1.в.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган ажилласугай.</p> <p>1.г.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн болон шийдвэрлэж хариу өгүүлэхээр ЗГХЭГ-аас шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, мэдээлэл, танилцуулга бэлтгэн улирал, хагас жилийнхийг 4, 7, 10-р сарын 10-ны дотор, жилийн эцсийнхийг дараа оны 1-р сарын 10-ны дотор ЗГХЭГ-т ирүүлж байсугай.</p> <p>3.НӨУЁ-ны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг ИТХ-д шилжүүлэн шийдвэрлүүлж, дүнг нэгтгэн улирал, хагас, бүтэн жилийн мэдээлэлд оруулж байхыг ЗГХЭГ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт</p>
54	"Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах" /2005-2010/ үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 2005.04.13. Дугаар 75.	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг НХХ-ийн сайд Ц.Баярсайхан, уг хөтөлбөрийг салбар, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай

55	Стандартчилал, тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай 2005.06.14. Дугаар 127.	2.Сорилт, шинжилгээ, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхэлдэг хөндлөнгийн лабораториудыг аттестатчилж, энэ чиглэлийн ажил үйлчилгээг “нэг цэг”-ийн зарчимд шилжүүлэх стандарт техникийн зохицуулалт тохирлын баримт бичгийн үндэсний мэдээллийн сүлжээ бий болгох арга хэмжээ авахыг Монгол улсын сайд Д.Дорлигжав, Стандартчлал хэмжил зүйн төвийн дарга Н.Жанчивдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
56	“Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөр батлах тухай 2005.06.22. Дугаар 138.	2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн, засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Н.Алтанхуягт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол улсын шадар сайд Ч.Улаан, ХХАА-н сайд Д.Тэрбишдагва, Үйлдвэр худалдааны сайд С.Батболд, НХХ сайд Ц.Баярсайхан, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
57	“40000 орон сууц” хөтөлбөр батлах тухай 2005.06.27. Дугаар 144.	2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, гадаад дотоодын байгууллага, компаний хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг барилга хот байгуулалтын сайд Н.Батбаяр, Сангийн сайд Н.Алтанхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. 4.“40000 орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймаг, нийслэл баригдах орон сууцны газрын байршлыг тогтоон зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга үүрэг болгосугай.

58	<p>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам/ 2005.07.06. Дугаар 154.</p>	<p>5. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>
59	<p>Үндэсний шигшээ баг байгуулах тухай 2005.09.14. Дугаар 189.</p>	<p>3.Үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх зорилгоор залуучуудын, оюутны болон өсвөр үеийн шигшээ баг байгуулан ажиллуулах асуудлыг 2005 онд багтаан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Ганди, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>
60	<p>Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай 2005.09.28. Дугаар 202.</p>	<p>4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж ажиллахыг бүсийн зөвлөлийн дарга, холбогдох амйгийн Засаг дарга нарт тус тус даалгаж, ИТХТ-ийн дарга нарт зөвлөсүгэй</p>
61	<p>Журам батлах тухай 2005.11.23. Дугаар 233.</p>	<p>1."Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-ыг 1-р хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ"-г 2-р хавсралт ёсоор тус тус баталж, 2006 оны 1-р сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр тогтоосугай.</p>

62	Хөтөлбөр батлах тухай 2005.11.30. Дугаар 234.	3. "Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг холбогдох сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай
63	Журам батлах тухай 2005.11.30. Дугаар 238	2. "Согтууруулах ундааг хураах, шинжилгээ хийх, улсын орлого болгож борлуулах журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол улсын сайд Д.Дорлигжав, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.
64	Хөтөлбөр батлах тухай 2005.12.07. Дугаар 244	3. "Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр"-ийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
65	"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр" батлах тухай 2005.12.14. Дугаар 246.	2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай

66	Хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай 2005.12.21. Дугаар 249. /Бөөний худалдааны сүлжээ/	1. “Хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2001.10.01-ний өдрийн 219-р тогтоолоор баталсан “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрт дараахь нэмэлт оруулсугай. “211./4 дүгээр үе шат 2005-2008 он/ Энэ үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн түүний үр дүнг дээшлүүлж, Баян-Өлгий, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган, Дундговь, Төв, Дархан-Уул аймгуудад “Бөөний худалдааны сүлжээ” байгуулж, түүхий эд бэлтгэлийг биржийн тогтолцоонд шилжүүлж, энэ ажилд бөөний худалдааны сүлжээнд ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлж дууссан байна”
67	Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002-2010/-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэл батлах тухай 2006.01.04. Дугаар 04.	2.Хөтөлбөрийн хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан ажлыг жил бүрийн Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. 3.Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад оруулах замаар хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

68	<p>Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II шатны үйл ажиллагааны үндсэн чиглэл батлах тухай 2006.01.04. Дугаар 05.</p>	<p>2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг НХХ-ийн сайд Ц.Баярсайхан, хөтөлбөрийг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p>
69	<p>Босго үнэ батлах тухай 2006.02.15. Дугаар 22.</p>	<p>1.Энэ тогтоолоор батлагдсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхий менежерт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайханд тус тус үүрэг болгосугай.</p>
70	<p>Тогтоолын зарим хавсралтыг шинэчлэн батлах тухай 2006.02.15. Дугаар 23.</p>	<p>1.Төсвийн байгууллагын, удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу тухайн жилийн төсвийн төсөл болон Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бүтээгдэхүүний ерөнхий ангийг баримтлан гаргаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.</p>

71	Хөтөлбөр батлах тухай 2006.03.22. Дугаар 50.	3."Экологийн цэвэр бүтээгдэхүүн" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сайн зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
72	Журам батлах тухай 2006.03.22. Дугаар 51.	2.Засгийн газрын агентлаг, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг баталж мөрдүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
	Төсвийн гүйцэтгэлийн сахилга. харивцлагыг	<p>1.Төсвийн ерөнхийлөн захирагч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:</p> <p>1.а.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх</p> <p>1.б.Төсвийн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулсан албан тушаалтантай хариуцлага тооцож, тухай бүр гаргасан зөрчлийг залруулж ажиллах</p>

73	чангатгах зарим арга хэмжээний тухай 2006.03.31. Дугаар 58.	<p>1.в.Төсвийн багцынхаа дотоод хяналтыг сайжруулах</p> <hr/> <p>1.г.Тухайн байгууллагын үндсэн үзүүлэлтүүд, урьд оны гүйцэтгэл зэрэгт үндэслэн төсвийн хөрөнгийн хувиарлалтыг оновчтой зөв болгох талаар арга хэмжээ авах</p> <hr/> <p>1.д.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.1-д заасны дагуу өөрийн үйл ажиллагааны үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хугацаанд нь гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх</p>
74	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр” батлах, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2006.04.03. Дугаар 64.	2.Архивын салбарт мэдээллийн технологи ашиглах, үүнтэй холбогдуулан судалгаа, төсөл хэрэгжүүлэн, архивын мэдээллийн сан бүрдүүлэх, төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг автоматжуулахад шаардагдах зардлын эх үүсвэрийг жил бүрийн төсвийн багцдаа багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.
75	Хамгаалалтын бүс тогтоох тухай 2006.04.05. Дугаар 70.	2.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, хамгаалалтын бүсэд барилга барихыг хориглох, дурсгалуудын хамгаалалтын бүсийн шон, тэмдэг тавих, шаардлагатай газруудад хашаа барьж хамгаалах талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Булган аймгийн Засаг дарга М.Оюунбатад үүрэг болгосугай.

76	<p>“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр батлах тухай 2006.04.26. Дугаар 91</p>	<p>3.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж явц, үр дүнг жилбүрийн II улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайд, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутаг дэвсгэрийнхээ хүн амыг бүрэн хамруулах, үзлэгийг шуурхай, чанартай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэхийг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>4.Мэдээллийн сан бүрдүүлэх, иргэдийг эрүүлжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа хувь хүний эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, эмнэлгийн ажилтанд үүрэг болгосугай.</p>
77	<p>Хөтөлбөр батлах тухай 2006.04.26</p>	<p>2.Малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>

	<p>2006.04.20. Дугаар 93.</p>	<p>3. Малын чанар сайжруулах хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад тусгах болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад санал болгон оруулах замаар хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>
<p>78</p>	<p>“Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр” батлах тухай 2006.05.03. Дугаар 99.</p>	<p>Үндэсний хөтөлбөрийг эрхлэх ажлынхаа хүрээнд болон тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>
		<p>3.а.Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн талаар санал боловсруулж ИТХ-д оруулах, нийгмийн халамжийн талаархи хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажлыг зохион байгуулах</p>

Хууль хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай
2006.05.24.
Дугаар 118.

3.б.Орон нутгийн ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төрийн бус байгууллага болон сум, хороодын Амьжиргааг дэмжих зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагаанд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах асуудлыг шийдвэрлэх

3.в.Орон нутгийн амралт, рашаан сувиллын газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр амруулж сувилуулах, иргэдийг төрөлжсөн асрамжид хамруулахдаа аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэж байх

3.г.Тухайн байгууллагад ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор хуульд заасан “Ахмадын сан” байгуулах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байх

		3.д.Сум хорооны нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод Нийгмийн халамжийн тухай хуульд заасан чиг үүргийг нэмж тусгах талаар холбогдох арга хэмжээ авах
80	“Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай 2006.06.28. Дугаар 150.	2.Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны тодорхой хэсгийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн дотоодын эх үүсвэрийг Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
81	Журам батлах тухай 2006.07.05. Дугаар 159.	2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулан хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

82	Журам батлах тухай 2006.07.05 Дугаар 160	2.Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэнд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг ЗГХЭГ хариуцна. Энэ үүргийг төрийн захиргааны байгууллагад сайд, агентлагийн дарга, нутгийн захиргааны байгууллагад бүх шатны ЗД, байгууллага аж ахуйн нэгжид тэдгээрийн дарга /захирал/ хариуцна.
83	Махны тогтвортой хангамжийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2006.07.26. Дугаар 178	“Мах бэлтгэн хадгалж, борлуулсан аж ахуйн нэгжид урамшуулал олгох журам” 5.Төв, суурин газрын зах зээлд нийлүүлэгдэж байгаа маханд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны эзлэх хувийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
84	Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2006.08.02. Дугаар 191.	/40000 орон сууц/ 2.Бондын хөрөнгөөр санхүүжигдэн барих орон сууцны газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
85	Орон нутгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2006.09.27. Дугаар 228	2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж хулгайн мал, мах тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг улсын орлого болгох, тууварлаж байгаа мал, тээвэрлэх маханд гарал үүслийн гэрчилгээ олгох талаар холбогдох арга хэмжээ авч, хяналт тавин ажиллах
86	“Журам батлах тухай” 2006.10.04. Дугаар 238	2. Аюултай хог хаягдлыг паспортжуулах журмыг тухайн нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тайлбарлан танилцуулах, түүний хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажиллах

87	<p>“Хөтөлбөр батлах тухай” "Ариун цэврийн байгууламжийг сайжруулах" 2006.10.11 Дугаар 246</p>	<p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулан гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх</p>
88	<p>“Төлбөр, хурамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2006.11.21. Дугаар 280</p>	<p>2. Үйлдвэрлэл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөр болон ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч байх</p>
89	<p>“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай” 2006.11.21. Дугаар 282</p>	<p>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2006 онд багтаан баталж, түүнд тусгагдсан асуудлыг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган залуучууд, иргэний нийгмийн оролоцоотойгоор салбар орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах</p> <p>3. Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусгах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглан санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p> <p>4. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 8 дугаар сард Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд ирүүлж байх</p>

90	Хөтөлбөр батлах тухай 2006.11.21. Дугаар 283	<p>2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж түүнд шаардагдах зардлыг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p> <p>3.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг жил бүрийн 1-р улиралд багтаан НХХ-ийн яаманд ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p>
91	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр батлах тухай 2006.12.27. Дугаар 315.	3.Хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрхэлсэн асуудлынхаа хүрээнд зохион байгуулан ажиллахыг холбогдох сайд, Засгийн газрын агентлагын дарга, бүх шатны Засаг дарга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон нутгийн салбар зөвлөлийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
92	Төрийн архивын талаар авах аргахэмжээний тухай 2007.01.24 Дугаар 25	1. Аймгуудын архивын тасгыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн бүтцэд оруулан алба болгон өөрчилөн зохион байгуулж шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

93	Нөрөн үржихүйн эрүүл мэнд үндсэний 3 дахь хөтөлбөр батлах тухай 2007.03.07 Дугаар 52	2.Үндсэний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан түүнд шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгаж байхыг ЭМ сайд Д.Туяа, Сайнгийн сайд Н.Баяртсайхан, аймаг нийслэлийн Засаг дарга нарт далга сугай
94	Хөтөлбөр батлах тухай 2007.04.04 Дугаар 85	2.Хөтөлбөрийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчийн зээл тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлж дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээг авахыг ХХАА сайд Д.Тэрбишдагва, ЭМ сайд Д.Туяа, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай
95	Ой угтсан бүтээлч ажлын тухай 2007.04.04 Дугаар 86	1.Монгол улсад газар тариаланг бие даасан салбар болгож хөгжүүлсэний 50 жилийн ойг 2009 оны 11 дүгээр сард тэмдэглэх болсонтой холбогдуулан 2 жилийн бүтээлч ажил өрнүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж ажилахыг Хүнс хөдө аж ахуйн сайд ДТэрбишдагва, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай

96	Нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрийг барагдуулах тухай 2007.05.16 Дугаар 116	Япон улс болон БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр малчдад зээлээр нийлүүлсэн нарны цахилган үүсгүүрийн хавсралтад дурдсан барагдуулаагүй байгаа төлбөрийг 2007 оны 2 дугаар улиралд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай
97	Иргэний бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2007.05.23 Дугаар 129	<p>1.Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор 2007 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сумдад иргэний бүртгэл хариуцсан 158 ажилтныг нэмж ажиллуулахад шаардагдах 189.789.600 төгрөгийг иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагын 2006 оны үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлж цаашид жил бүрийн төсөвт тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймгийн Засаг дарга нарт далагасугай</p> <p>2. Сумдад иргэний бүртгэл мэдээлэл хариуцан ажиллах орон тооны ажилтныг ажлын байр шаардлагтай техник хэрэгслээр ханган цаашид иргэний бүртгэл хариуцсан орон тооны ажилтныг сум хороо бүрт ажиллуулах зардлыг нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхийг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p>
98	Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай 2007.06.20 Дугаар 150	2.Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлаж түүнд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвт тусгаж байхыг Эрүүл мэндийн сайд Д.Туяа, сангийн сайд Н.Баярсайхан, Аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай

99	Хөтөлбөр батлах тухай 2007.09.12 дугаар 225	2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Жөндөрийн тэгш байдлын үндэсний хороонд, хариуцсан чиглэл тус бүрийнхээ арга хэмжээг эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай
100	Ахмад дайчдын орон сууцны тухай 2007.09.28 Дугаар 250	<p>2. Ахмад дайчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулж ьодорхой хэмжээний хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусган шийдвэрлэж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Барилга хот байгууллалтын сайд Ж.Наранцацралт аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай</p> <p>3.Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр , 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх нөхцлийг тусган уг асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг барилга хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай</p>

101	журам батлах тухай 2007.10.03 Дугаар 256	2. энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, аймаг нийслэл сум дүүргийн Засаг дарга нарт даалгасугай
102	Барилга дэд бүтцийн салбарт авах зарим арга хэмжээний тухай 2007.10.31 дугаар 282	<p>1. Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулан зураг төсөл нь бэлэн болоогүй барилга байгууламжийг улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгахгүй байхыг төсвийн Ерөнхийлөн захирагч нарт даалгасугай</p> <p>5.Барилга хот байгуулалтын сайд Ж.наранцацралт, Зам тээвэр аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Түлш эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, аймаг нийслэлийн Засаг дарга нарт дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай</p> <p>а/ нийлсэл болон аймаг бүсийн тулгуур төв хот, сум суурин газрын нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг төслийг дэс дараатай боловсруулах, нийслэлийн нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2007 онд багтаан боловсруулж мөрдүүлэх</p> <p>б/ аймаг нийслэлд ажиллаж байгаа барилга хот байгуулалтын албаны үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулан жигдрүүлж , мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл, инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зураг, техникийн баримт бичгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх аж ахуй нэгжийн мэдлээс авч тус шилжүүлж архивлах</p>

103	Хөтөлбөр батлах тухай 2007.11.07 Дугаар 283	2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2008 оноос эхлэн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Хүнс хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, аймаг нийсэллийн Засаг дарга нарт тус тус даалгасугай
104	Хөтөлбөр батлах тухай 2007,11,21 Дугаар 303	2, Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Баяртсайхан, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын үүрэг гүйцэтгэгч Ө.Энхтүвшин, аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай
105	Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай 2007,12,26 Дугаар 349	9, Албан ажлын автомашин хэрэглэдэг албан тушаалтан өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд ажлын хоногт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр 1 км-ийг 200 төгрөгөөр тооцон зардлыг сар тутам түүнд олгож байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт зөвшөөрсүгэй 11, Эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх хэрэглэсэн шатахууны зардлыг төлүүлэх явдлыг 2008 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн таслан зогсоохыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосугай

		<p>12, Энэ тогтоолд заасан нийтлэг жишгийг баримтлан аймаг нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудын автомашин ашиглалтын журам автомашины тоо төрлийг мөрдүүлэх арга хэмжээ авахыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай</p>
31	Аймаг нийслэлийн Засаг дарга нарт 2009,09,02 Дугаар 56	1,2 жижиг дүнд үйлдвэрийн бэлэн болсон төсөл шалгаруулах ажлыг шуурхай зохион байгуулан зээл олгох асуудлыг хүндрэл багатай болгох талаар банкттай тохиролцож ажиллах үүргийг аймаг нийслэлийн "Дэд комисс"-т өгч ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав гэжээ

32	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2009,10,28 Дугаар 68	1,5 2009 оны төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулж үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн өрийг барагдуулах урсгал засвар эд хогшил шинэ жилийн арга хэмжээ болон бусад баяр ёслолын арга хэмжээнд хавтгайруулан зардал гаргахгүй байх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захиргагч нарт даалгав 1,6 Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав
33	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 2009,11,11 Дугаар 70	2, Томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн өвчлөлд жирэмсэн эхчүүд илүү өртөх эрсдэл ихтэй байгаа тул өөрийн байгууллагад ажиллаж байгаа жирэмсэн эхчүүдэд Хөдөлмөрийн тухай хулийн дагуу олгодог жирэмсний амралтын өмнө нь 1 сарын цалинтай чөлөө олгох санаачлага гарган ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн ерөнхий менежер нарт чиглэл болгов гэжээ
34	Аймаг нийслэлийн Засаг дарга нарт 2009,11,11 Дугаар 70	11,2 Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2009 оны 3-р улирлын хэрэгжилтийн явцын тухай Монгол улсын сайд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбоотой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн заалт арга хэмжээ бүрийг хяналтанд авч мэдээ тайланд бүрэн хамруулах, биелэлтийг бодитойгоор тайлагнах 2009 оны 2-р улиралын байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудыг биелүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгууж ажиллахыг сайд Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгав гэжээ

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор
батлагдсан журмын 4 дүгээр хавсралт

**ЭГЧИЙН ЗАРЛИГ,
ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

2009 оны жилийн эцсийн байдлаар

Хэргжилтийн явц
/Тасарсан болон удааширч буй шалтгааныг
тодорхой бичнэ/

тогтоол

2009 оны үндсэн чиглэлд 2 салбарын 3 зорилт 7 арга хэмжээ төлөвлөж хэрэгжилт 94,3 хувьтай байна. Үндсэн чиглэлийн зорилтуудыг аймгийн эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэнд тусгаж аймгийн ИТХ-аар батлуулж сум орон нутагт газар дээр нь 2 удаа шалгаж биелэлтийг тооцон, хэрэгжилтийн явц байдлыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчидэд танилцуулж ажиллаа.

/Хэрэгжилт 94,0 хувь/

зарлиг

лөмж

азрын тогтоол

Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг 100 хувь усалгаатай тариалж байгаагаас гадна Сэлэнгэ сумын Ингэттолгой, Оргилдэлгэр, Өрмөгтий Хас тав, Орхон сумын Орхон мандал ХХК –иуд 676 га талбайд усалгаатай үр тариа тариалж, төмс хүнсний ногоог 100 хувь усалгаатай тариалж байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд 34 нөхөрлөл үйл ажиллагаагаа эхлээд байгаа бөгөөд Орхон сумын 13, Хангал 4, Сэлэнгэ 11, Тэшиг 1, Бугат 2 нөхөрлөл улсын төсвийн хөрөнгөөр талбайн тусгаарлалт хийлгэлээ. 2008 оноос хойш аймгийн хэмжээнд нийт 10 сумын 45 багт 52 удаа давхардсан тоогоор 904 хүнд сургалтыг хийгээд байна. Ойн тухай шинэ хуулийн дагуу нөхөрлөл, иргэдийн оролцоотойгоор ойг хамгаалах Хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх төслөөс “Хамтын оролцоо” сэдэвт сургалтыг, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, байгаль хамгаалагч, сумын засаг даргын орлогч, ИТХурлын дарга, БОХУБайцаагч, нөхөрлөлийн гишүүдийг оролцуулан Бугат, Хангал суманд 4 хоногийн сургалтыг зохион байгуулав.

/Хэрэгжилт 100.0 хувь/

2009 онд авто замын санд 114,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 111,0 сая төгрөг төвлөрүүлж, 75,24 сая төгрөг зарцуулаад байна. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр Булган хотын Зүүн түрүүний гүүр, Булган, Сэлэнгэ сумдын замыг засварлаж, Булган хотын гэр хорооллын замыг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна. Булган хотын гэр хорооллын 0,65 км замыг хатуу хучилттай болгоход 247,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатайгаас гэрээний дагуу эхний ээлжинд 52,93 сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна. 2010 оны 7 дугаар сард ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй.

/Хэрэгжилт

90,0 хувь/

Улсын төсвийн 12.0 сая төгрөгийн хөрөнгөөр 8, Тогтвортой амьжиргаа төслийн 3 сая 958.0 мянган хөрөнгөөр 5 булаг шандны эхийг тохижуулан хамгаалах ажил хийгдлээ. Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Дашинчилэн суманд 0,24 га усан талбай бүхий 1 хөв цөөрөм, Рашаант суманд хуучин цөөрөм шанд байсан газарт тус бүр 0,02 га усан талбай бүхий 6 хөв цөөрөм байгуулсан. Аймгийн хэмжээнд улсын төсвийн 234.0 сая төгрөгийн хөрөнгөөр 18 худаг, Чех улсын буцалтгүй тусламжаар 210 сая төгрөгийн өртөгтэйгээр 14 худаг, Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн шугамаар 48,0 сая төгрөгийн өртөгтэйгээр 4 худаг, Дэлхийн зөн ОУБ-ын 36,0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 худаг шинээр гаргаад байна. Мөн “Дэлхийн зөн” ОУБ-ын хөрөнгөөр 1 худгийг 5,0 сая төгрөгийн өртөгтэйгээр сэргээн засварласан. Уул уурхайн болон бусад үйлдвэр, үйлчилгээний газруудтай ус ашиглах гэрээг байгуулан ажиллаж тайлант хугацаанд 1383383821 төгрөгийг аймгийн төсөвт орууллаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

“Хүүхдийн сайн сайхны төлөө” Бангкокийн тунхаглалд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж Хүүхэд хөгжил хамгааллыг сайжруулах үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаа. Үндсэн чиглэлийг Хүүхдийн эрх, Хүүхдийн хөгжил, Хүүхдийн эрүүл мэнд, Хүүхдийн боловсрол, Хүүхдийн оролцоо гэсэн чиглэлээр боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Европын холбооноос хэрэгжиж байгаа “Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээл” төслийн хүрээнд 2009 оноос эхлэн аймаг орон нутгийн хэмжээнд 2 удаагийн сургалт зохион байгуулж багаж тоног төхөөрөмж нийлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад байна. Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, Мерси Кор байгууллагаас шувууны томуу өвчний халдвар хамгаалалын хувцас, бусад багаж тоноглол, оношлуур багажууд гэх мэт 33 нэрийн 10.4 сая, Улсын хөрөнгө оруулалтаар 24 нэр төрлийн 12.8 сая төгрөгний оношлуур нийлүүлэгдсэн буюу нийт 24.9 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгджээ. ХЯБХХН-ээс 454.0 мянган төгрөгний микроскоп, 543 мянган төгрөгний тоног төхөөрөмж авч мал эмнэлгийн оношлогооны үйл ажиллагаа сайжирлаа. Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр адууны цус багадаа өвчин ям, сүрье, хээл хаялтанд нөлөөх өвчин, бруцеллээс өвчний ээлжит шинжилгээг зохион байгуулж байна. Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 1298.9, паразиттах өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 1209,9 мянган мал хамрагдсан байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Энэ онд ОХУ-ын Буриад улсын Закаменск аймагт 1000 үхэр хөлөөр нь нийлүүллээ. Аймгийн төвд мал, мах бэлтгэлийн нэгдсэн цэг, хөргүүртэй зоорь барих аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж 50,0 сая төгрөгний хөнгөлттэй зээл олгосоноор үйлдвэрийн барилга угсралтын ажил 90,0 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд "Хутаг- Өндөр мах маркет" ХХК махны хөргөлтийн зоорийн тоног төхөөрөмжийг шинэчилж аймгийн төвийн хүн амд хагам боловсруулсан мах махан бүтээгдэхүүн нийлүүлэхээр ажиллаж байна. Мах бэлтгэх, хагас боловсруулсан мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх 2 аж ахуйн нэгжийн төслийг дэмжиж хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ХХААХҮЯ- д уламжилсан боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Сумдын халаалтын системийг шинэчлэх, өргөтгөхөд 350 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж түлш бага хэрэглэдэг найдвартай зуухаар хангах зорилт тавьж Хутаг-Өндөр сумын төвлөрсөн халаалтын зуух, Баян-Агт, Бүрэгхангай, Баяннуур, Тэшиг сумдын сургууль, Хялганат тосгон, Дашинчилэн, Орхон сумдын соёлын төв, Тэшиг сумын цэцэрлэг, дотуур байр зэрэг газруудад шинээр халаалтын тогоо суурилуулах, доторхи халаалтын системийг шинээр угсрах, өөрчлөх ажлууд хийгдлээ.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороог байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 134-р тушаал, хөдөлмөр хамгааллын стандартын хэрэгжилтийг хангуулах талаар 110 аж ахуйн нэгж, байгууллага, 3 салбар нэгж, 45 худалдаа үйлчилгээний цэгийг шалган зөвөлгөө өгсөн. Уг арга хэмжээнд төсвийн 39, төрийн өмчийн оролцоотой 3, хувийн хэвшлийн 64, гадаадын хөрөнгө оруулалттай компани1, салбар нэгж 3, цэг байгууламж 45 хамрагдлаа. Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажлын байрны аттестатчиллын талаар болон ажлын байр бүрийн аттестатчиллын карт бөглөх талаар аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан, захирал, эрхлэгч 50, үйлдвэр үйлчилгээний 132, 16 сумын 353 байгууллагын 405 нийт 587 хүнд сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөдөлмөрийн тухай хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж хамтын гэрээ, гурван талт гарээ / төрийн захиргаа, үйлдвэрчний байгууллага, ажил олгогч эздийн холбоо/ хэлэлцээрийг байгуулан бүртгэж асуудлыг тодорхой ажилтан албан ёсоор хариуцан ажиллаж байна. Хамтын гэрээг дүгнэх ажлын хэсэг ажиллаж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилан ажиллаж байна.

/Хэрэгжилт 85,0 хувь /

Цагдаагийн хэлтсийн шуурхай эргүүлийн автомашиныг аймгийн ГХУССангийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэлээ. **/Хэрэгжилт 100 хувь/**

Аймгийн халдварт өвчинтэй тэмцэх баг Сумдад онцгой комисс, онцгой байдлын штабаас энэ чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд энэ онд Баянуур, Гурванбулаг суманд гарсан 9 удаагийн галзуу өвчний голомтод ажлын хэсгийн баг ажиллаж өвчлөлийг тархаахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллан өвчнөөр үхсэн мал, амьтны сэг зэмийг зориулалтын дагуу булж устган голомтын бүсэд хязгаарлалтын дэглэм тогтоон мөрдүүлж ажилласан. **/Хэрэгжилт 100 хувь/**

Аймгийн хэмжээнд худалдаа үйлчилгээний 20 гаруй цэг кассын машин ашиглаж байгаа бөгөөд 2009 онд шинээр 2 аж ахуйн нэгж кассын машин үйл ажиллагаандаа нэвтрүүлээ. Цаашид аж ахуйн нэгжүүдийг кассын машин хэрэглэдэг болгох талаар шаардлага, хяналт тавьж ажиллаж байна. **/Хэрэгжилт 90.0 хувь/**

2000 оноос Дэлхийн Зөн ОУБ нь манай аймагт хэрэгжиж мод үржүүлэг, ойжуулалтын ажил хийж мөн цөлжилт доройтсон орчныг нөхөн сэргээх ажлыг хамтран гүйцэтгэж ирсэн. 2008 оноос НҮБ, Хүнс хөдөө аж ахуйн байгууллага нь байгаль орчны чиглэлээр "Хамтын оролцооны ойн менежментийн чадавхийг бэхжүүлэх" төсөл хэрэгжсэнээр ой бүхий 6 суманд 34 нөхөрлөл байгуулж, үйл ажиллагааг нь дэмжиж байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг 2 үе шаттай үзэж дутуу хийгдсэн ажилд хугацаатай үүрэг өгч ажиллаа. Аймгийн дүнгээр 85 хувь хангаж Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн сум хангалтгүй дүн авсан. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд УЦУОШБ-ын оролцоотойгоор дулааны улирлын төлөв байдлын үнэлгээний дагуу олон жилийн түймрийн улирлын нөхцөл байдлыг тооцон төлөвлөгөөндөө тодотгол хийж санхүүгийн хэрэгцээг тухай бүрд нь танилцуулан шийдэж ирсэн бөгөөд энэ онд нийт 10030.0 мянган төгрөгийг энэ чиглэлээр Засаг даргын нөөцөөс гаргасан болно. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Сумдын түгээмэл зориулалтын мэргэжлийн ангийн гал унтраах бүлгийн томилгоот иргэдийн бэлэн байдлыг жилд нэг удаа 4-р сард нэгдсэн журмаар шалган дадлага сургууль хийж хэвшсэн ба түймрийн улиралд тэдгээрийг түймрийн аюулын ангиллын дагуу бэлэн байдлыг хангуулах арга хэмжээ авч байгаа сумын төвд байгааг нь түймэр унтраах бүлэгт оруулж эхний ээлжинд, хөдөө байгааг нь байршлаар нь түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Өнөөдрийн байдлаар ой хээрийн түймэр байнга гардаг сумдад дүйцүүлэх албаны дайчдын тоо хэт цөөн байгаа тул нэгдсэн зохион байгуулалтанд оруулж түймэр унтраах ажилд оролцуулах ажил хийгдээгүй. Аймгийн хэмжээнд жилд 30 хүн дүйцүүлэх албанд татдаг бөгөөд сургалтын хугацаа, мэргэшүүлэх баг бий болгох хөрөнгө мөнгөний бололцоо тааруу байдаг

/Хэрэгжилт 50,0 хувь/

Малчын өвөлжөө хаваржаанд хагаалалтын зурвас байгуулах болон үнс нурмаа тагтай саванд хийж хэвших талаар багийн Засаг дарга нараас байгуулах гэрээнд тусган хэрэгжүүлж байгаа юм.

/Хэрэгжилт 80,0 хувь/

Түймрийн аюултай улиралд түймэр гарч болзошгүй бүс нутгуудад аялал зугаалга болон ойн дагалт баялаг ашиглахыг хориглосон шийдвэр гаргаж байгууллага аж ахуйн нэгжүүдэд мөрдүүлэх арга хэмжээ авч байгаа бөгөөд энэ шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн байгууллагууд оролцохоос гадна тухайн орон нутагт сум, багийн Засаг дарга нар, байгаль хамгаалагч нар хяналт тавьж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Сумдын Засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд мал сүрийг эрүүлжүүлэх паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь зохион байгуулах, мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, гурвалсан гэрээ байгуулж ажиллах талаар тусгаж өглөө. Манай аймгийн хойд бүсийн сумдын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан борлуулах захыг Эрдэнэт хотод байгууллаа. Аймгийн төвд малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх зах байгуулахаар төсөл, зураг төсвийг боловсруулж, газрын асуудлыг шийдвэрлээд байна. Арьс ширийг захын ченжүүд цуглуулж бэлтгэн нийлүүлж байна.

/Хэрэгжилт 80.0 хувь/

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагын дарга эрхлэгч нартай уулзалт ярилцлага зохион байгуулж тэдний санал санаачлагад тулгуурлан, үйлдвэржилтийг дэмжих жилийн ажлын арга хэмжээтэй уялдуулж шинэ ажлын байр бий болгох арга хэмжээг хэрэгжүүлж байна. ХЭД, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр бий болгох зорилгоор 163 зээлдэгчид 158.2 сая төгрөгний зээл олгож, 252 шинэ ажлын байр бий болгов. Хөдөлмөрийн зах зээл, АОЭ-с 868, ажлын байрны захиалга хүлээн авч эрэлтэд нийцүүлж 621 хүнийг ажилд зуучлан 259 хүнийг ажлын байраар хангав.

/Хэрэгжилт

100.0 хувь/

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд сум бүрт 50,0 сая төгрөг бүхий сум хөгжүүлэх сан байгуулхаар тусгасан боловч 2009 онд хөрөнгө шийдвэрлэгдээгүй болно.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Сумдын хөгжлийн санд олгох хөрөнгө 2001 оноос өнөөг хүртэл хөрөнгө хуриарлагдаж ирдэггүй, 1998 онд сумдын хөгжлийн санд 75 сая төгрөгнөөс төлөгдөөгүй үлдсэн 23,3 сая төгрөг байна, энэ зээлийн төлөлтийг жил бүр тайланд тусгаж байна

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн төвд “Хог боловсруулах үйлдвэр” байгуулах санал, зураг төсвийг хийж хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Байгаль орчин аялал жуулчлалын яаманд явууллаа. Орон нутгийн сангаас Булган сумын иргэн Баярмагнай, Мөнхбат нарын Хаягдал гялгар уут, хуванцар боловсруулах төсөлд 10,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэнээр тоног төхөөрөмжөө худалдан авч суурилуулж цехийн барилгын дотоод засварыг хийж байна. Хагас боловсруулсан хог хаягдлыг Дархан-Уул аймагт нийлүүлэх гэрээ хийгээд байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

"Цэвэр орчин аяныг зарлаж, Булган аймгийн төвийн эргэн тойрны гуу жалга, гудамжинд бий болсон зөвшөөрөлгүйгээр эзэнгүй хог хаягдлын цэгүүдийг цэвэрлэн цэгцэллээ. Айл өрх албан газар болон нийтийн эзэмшлийн 3982.3 га газрын хогийг цэвэрлэн 2651.5 тн хогийг тус тус ачиж зайлуулав. Баян-Агт сумын төвийн хогийн цэгийг 238 хүний бүрэлдэхүүнтэйгээр 20 га талбай бүхий хогийн цэгийг зөөж цэвэрлэн 2 га бүхий талбайг шинээр журамлан тогтоов.

/Хэрэгжилт нь 90,0 хувь/

Хогны менежментийг боловсронгуй болгож бүтэц зохион байгуулалт чиг үүрэг хогны санг хэрхэн бүрдүүлэх талаар асуудал боловсруулж аймаг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэж 2009 оны 04 сараас эхлэн хот тохижилт үйлчилгээний анги нэртэйгээр 25 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж ногоон байгууламжийн цэцэрлэгжүүлэлт нийтийн эзэмшлийн цэвэрлэгээ хог хаягдал ачиж тээвэрлэх цэвэрлэх хогны санг бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Хог хаягдлыг ялгаж худалдан авах үйл ажиллагааг дэмжиж 2-р багийн иргэн Баярмагнай Мөнхбат нарын хамтарсан хог хаягдалд анхан шатны боловсруулалт хийж цех байгуулах төслийг ЖДҮ-ийг дэмжих сангаас 10 сая төгрөгний зээл олгож гялгар уут, хуванцар сав хагас боловсруулж эхэллээ.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн ургацын комиссыг ХХААЖДҮ-ийн газрын БЗА-нд ажиллуулж хаврын тариалалтын мэдээг 7 хоног бүрийн 4 дэх өдөр, ургац хураалтын мэдээг өдөр бүр хүлээн авч ажиллаа. Мөн статистикийн хэлтэст мэдээг сар бүрийн 14, 28 нд мэдээлж байхыг сумдын Засаг дарга нарын гэрээнд тусгасан

/Хэрэгжилт 100,0 хувь/

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг байгалийн эрсдлээс хамгаалах даатгалд хамруулах зорилгоор аймгийн газар тариаланчдын зөвлөгөөний үеэр сургалт мэдээлэл зохион байгууллаа. Үр үржүүлэх зорилгоор тариалалт хийж байгаа аж ахуй нэгжүүд даатгалд хамрагдсан.

/Хэрэгжилт 70,0 хувь/

БСГ-т зайны сургалт зохион байгуулах техник хэрэгслийг суурилууллаа. БСШУЯ, АББЗСҮТ-тэй хамтран 2010 онд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус аймгийн 5 суманд “Чех Каритас” төслийн хүрээнд зайны сургалтын богино долгионы станц 10-ыг суурилуулж , сургалтанд ашиглаж эхэллээ. БСГ-ын Гэгээрэл мэдээллийн төвд зайн сургалтын чиглэлээр багш нарын заах арга зүй, компьютер сургалт, гадаад хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр 30 гаруй төрлийн CD, DVD, электрон хичээлийн сан бүрдүүлэн багш, суралцагч, мэргэжилтнүүдэд үйлчлэх боломжтой боллоо.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аж ахуйн нэгж байгууллагаас Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг ХХҮХэлтсийн тусгай дансанд тушаалгаж байна. Манай аймагт 25 болон түүнээс дээш ажилтан албан хаагчтай аж ахуйн нэгж, байгууллага 75 байдгаас одоогийн байдлаар бүх сумдын Хүн эмнэлэг, Сургууль, Цэцэрлэг, Цэргийн анги, Засаг даргын Тамгын газруудаас хөгжлийн брхшээлтэй ажиллагсадын судалгааг авч дүгнэлт хийж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж ажлын байртай болгох хөтөлбөрт хамруулах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдрийг тэмдэглэн өдөрлөг зохион байгуулах, спорт, урлагийн уралдаан тэмцээн зохион байгуулах, уран бүтээлийн үзэсгэлэн гарган дүнэх зэрэг тэдний эрэлт хэрэгцээнд тохирсон олон хэлбэрийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт 90,0 хувь/

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, шинээр байнгын болон түр ажлын байр бий болгох зорилгоор 17 суманд 34 төслөөр Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулан, зам талбай засварлах, багийн төв тохижуулах, мал ангилалын хашаа, гар худаг, ой нөхөн сэргээлт, хүүхэд залуучуудын талбай, ногоон байгууламж, наадмын талбай засварлах, хөшөө тохижуулах, булаг ус хамгаалах, гудамж талбайн гэрэлтүүлэг зэрэг ажилд тодорхой ажилгүй, орлого багатай 664 иргэнийг нийтийг хамарсан ажилд хамруулж 62 сая төгрөгний ажил үйлчилгээ үзүүллээ.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Орон сууц үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг авахыг сум бүрт даалгасан бөгөөд суманд 4 айлын орон сууцууд Булган суманд 30 айлын орон сууцыг шинээр барьж, ашиглалтанд оруулаад байна. /Хэрэгжилт 100,0 хувь /

Хөдөлмөр эрхлэлтийн талаар аймгаас баримтлах бодлогыг батлуулан, хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт ажилгүйчүүдийн бүртгэлд 2009 оны 11 сарын байдлаар 2392 хүн бүртгэгдснийг ажилд зуучлах, байнгын болон улирлын байраар хангах арга хэмжээг авлаа. Үүнд: Ажил олгогчдоос ирүүлсэн 868 ажлын байрны захилгад 621 хүнийг зуучлан, шинээр бий болгосон байнгын ажлын байранд 673 хүнийг, улирлын ажлын байранд 259 хүнийг ажлын байраар хангаж, ажил идэвхитэй эрж хайж байгаа нийт хүний 64.9 хувийг нь хөдөлмөр эрхлүүллээ.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Тайлант онд манай аймагт улсын төсвөөс хөрөнгө тусгагдаж ирээгүй байна.
/Хүлээгдэж байгаа/

Швед улсын Льусдал хамтралтай хамтран “Хамтын ажиллагаа-Тогтвортой хөгжил ба орон нутаг дахь хогны менежмент” нэртэй төслийг хэрэгжүүлж, хогны менежментийг сайжруулах талаар харилцан туршлага солилцон ажиллаж байна. **/Хэрэгжилт 70.0 хувь/**

Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гэнэтийн хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж, айл өрх аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтын үзлэг шалгалтыг тогтмол явуулж байна. Цагдаагийн хэлтсийн албан хаагчдыг тэгш хэмийн системээр ажиллуулж, хороо, гудамж, албан байгууллагуудыг хариуцуулан өгсөн бөгөөд Булган сумын багуудын хэсгийн ахлагч нарын сургалтыг зохион байгуулж, хариуцсан цагдаагийн ажилтнуудтай уулзалт хийлээ.
/Хэрэгжилт 90,0 хувь/

Орон нутгийн чанартай авто зам болон аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын автозам, замын байгууламж, талбайгаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авдаггүй. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Батлан хамгаалахын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, дайчилгааны даалгавар бүхий цэргийн анги байгуулагатай хийсэн хамтарсан тодотголын мөрөөр дайчилгааны бэлтгэл нөөцийн 40 хүний бүрэлдэхүүнтэй сургалтыг Булган аймгийн цэргийн үүрэгтний сургалтын төвд 2009 оны 5 дугаар сарын 15-29-ний өдрүүдэд 14 хоногийн хугацаатай зохион байгуулж шинээр болон шилжүүлэн мэргэжил эзэмшүүлж дайчилгааны төлөвлөгөөний шаардлагатай командууд оногдуулан дансаллаа. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Тайлант хугацаанд 3 рашааны эхийг хамгаалах арга хэмжээ аваад байна. Мөн 4 рашааны эхийг хамгаалах, тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна. **/Хэрэгжилт 50,0 хувь/**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтэнд тусган ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн судалгааг гарган, 5 сумын эмнэлэгийг эх, нярайн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, 5 сумын эмнэлгийг магадлан итгэмжлэлд хамруулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2 удаа гарган, холбогдох байгууллагад хүргүүлсэн. **/Хэрэгжилт 90,0,0 хувь/**

Архи тамхины шалтгаант эмгэг судлалын төвийн Булган аймаг дахь салбартай хамтран Архинд донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг явуулж байна. ГХУССангаас Архины хор уршиг, эмгэгийг харуулсан сурталчилгааны 3 төрлийн материалыг хэвлүүлэн, Аддиктологийн лекцийг төвийн лектор багшаар хийлгэж 200 гаруй ахлах ангийн сурагч, төрийн албан хаагчид, иргэдийг хамрууллаа. **/Хэрэгжилт 70,0 хувь/**

Тэнэмэл амьдралтай иргэдийг ажлын байраар хангах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар 5 иргэнийг зохих хууль журмын дагуу шийдвэр гарган асрамжийн газруудад хүргүүлэн ажиллаа. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр 3 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр Төрийн бус байгууллага нь Булаг шанд, ойжуулалт нөхөн сэргээлт, ногоон хэрмийн туслах зурвас байгуулах зэргийг орон нутгийн ЗДТГ, байгаль орчин, нутгийн иргэдтэй хамтран үйл ажиллагаа явуулж байна.

Дархан-Уул аймгийн ХААИС-ийн харъяа ургамал газар тариалангийн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгээс зохиож буй “Байгаль орчны шинэчлэл-2” төслийн хүрээнд байгаль хамгаалагч нарын сургалтыг 07-р сарын 17-24-ний хооронд 7 хоногийн хугацаатай 100 цагийн агуулга бүхий онол, дадлага гэсэн 2 хэсэгтэйгээр хичээллэсэн. Мөн Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ болон байгаль хамгаалах сонирхолтой иргэдэд “Байгаль орчинг хамгаалах” талаар жижиг төсөл боловсруулах сургалтыг зохион байгуулан 20 гаруй иргэд сургалтанд хамрагдсан.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд 42 хоршоо үйл ажиллгаа явуулж байгаагийн 18 хоршоо газар тариалангийн чиглэлээр 15 хоршоо мал аж ахуйн чиглэлээр 12 нь бусад чиглэлээр үйл ажиллгаа явуулж байна. Газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг тэргүүн ээлжинд дэмжиж төсөл хөтөлбөр болон гадаадын зээл тусламжинд хамруулах чиглэлээр Ургацын түрүү, Хутагноого, сүмийн нуга зэрэг хоршоодыг хамрууллаа. аймгийн тэргүүний хоршоо шалгаруулах журам, хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөр -2 боловсрууллаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуульд заасан тохирлын баталгаанд хамрагдах шаардлагатай 12 аж ахуйн нэгжийн 47 нэрийн бүтээгдэхүүн, 204 аж ахуйн нэгж иргэдийн 8 нэрийн 204 бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж гэрчилгээ олгон улирал бүр тайлан мэдээг холбогдох дээд байгууллагад хүргүүлж байна.

/Хэрэгжилт -100.0 хувь/

Төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зардлын зүйл тус бүр дээр төлөвлөн , ня-бо бүртгэлд бүртгэн тайлан гаргаж байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн Засаг даргын захирамжаар төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах комиссыг санхүү, газар , барилга болон бусад салбар хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан томилж, хийгдэх ажлын төлөвлөгөө ,сумдад ажиллахад шаардагдах шатахууны зардлыг батлуулан ажиллалаа. Дахин үнэлгээний ажлын явцыг хянах , зөвлөгөө өгөх ажлын хэсгийг бүх сумдад ажиллууллаа . Сум байгууллагуудад байгаа актлагдах хөрөнгө , ашиглалтгүй болон илүүдэлтэй байгаа хөрөнгийн байдалтай танилцан саналаа аймаг, сумын ИТХтэргүүлэгчдээр хэлцүүлэн шийдвэрлүүлээ. Хөрөнгийн дахин үнэлгээний явцад зарим сум байгууллагуудад бүртгэлтэй боловч үрэгдэж алга болсон хөрөнгийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад саналаа тавиад байна. Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн дахин үнэлгээний ажил холбогдох заавар журмын дагуу хийгдэн 2009 оны тайланд тусгагдахад бэлэн болоод байна .

/Хэрэгжилт 100.0 хувь/

Төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээнд нийт 16 сум 1 тосгоны 115 байгууллага , аймгийн шууд харъяа 29 төсөвт байгууллага , орон нутгийн өмчит 1 компани , өрхийн эмнэлэг , эмийн эргэлтийн санг хамруулж 30 гаруй тэр бум төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэнийг мэдээллийн санд нэгтгээд байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Булган Булган аймаг газар хөдлөлтийн 8 баллд оршдог. Аймгийн хэмжээний 15 сумын төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгууллаа. 2009 онд шинээр баригдсан барилга байгууламжууд нь геологийн дүгнэлтийн дагуу газар хөдлөлтөнд тэсвэрлэх чадварыг 8 баллаар тооцож баригдсан. **/Хэрэгжилт -70,0 хувь /**

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Дашинчилэн суманд 0,24 га усан талбай бүхий 1 хөв цөөрөм, Рашаант суманд хуучин цөөрөм шанд байсан газарт тус бүр 0,02 га усан талбай бүхий 6 хөв цөөрөм байгуулсан.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Дашинчилэн сумын Хараат багийн нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож байсан 160 иргэдийг шалгаж дахин тус газарт алт олборлохгүй байх баталгааг гаруулан авч, үйл ажиллагаанд ашиглаж байсан алт хайгч 7, пирбор 20 гаруйг хураан хариуцлага тооцон ажиллаа. Мөн Бүрэгхангай сумын 3-р багийн нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож байсан 180 иргэдтэй уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааг зогсоон үлээгч 3, 30-аад хүрз, лоом, зээтүү хураалаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Уул уурхайн орд, ашигт малтмалын нөөц бүхий Бүрэгхангай, Дашинчилэн, Сайхан, Тэшиг зэрэг сумдын 300 гаруй иргэдэд холбогдох хууль, тогтоомжуудыг сурталчилан, уулзалт зохион байгуулан ажиллалаа.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Рашаант суманд орших Хөгнө-Тарны Эрдэнэ хамбын хийд орчмыг тэмдэгжүүлэх хамгаалж байна. Мөн Рашаант сумын Хадат хошуу, Тахилт нуур, Элсэн тасархай зэрэг газар нутгийг хамгаалан тэмдэгжүүлсэн.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Орхон аймаг дахь салбар зөвлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 06 дугаар сарын 27- 28 өдрүүдэд Орхон аймгийн ХАҮТ, аймгийн ЗДТГ аас хамтран зохион байгуулсан "Эрдэнэт түншлэл 2009" олон улсын үзэсгэлэн яармагт аймгийнхаа үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, оны шилдэг аж ахуйн нэгж, шилдэг бизнес эрхлэгчдийг тодруулах"ENTERPRENEUR-2009" арга хэмжээнд 2 аж ахуйн нэгжийг тодорхойлж материалыг хүргүүлээд байна.

/Хэрэгжилт - 90.0 хувь/

Улсын үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгахаар төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг тооцон ажиллаж ирлээ. Мөн тогтоолын биелэлтийг сум, байгууллагаас улирал бүр тооцон авч Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн Засгийн газарт мэдээлж байна. Төсвийн Ерөнхийлөн захирагч нар жил бүрийн төсөвтөө архив, бичиг хэргийн ажилтан нарыг давтан сургах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хийж байна.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа архив, бичиг хэргийн ажилтан нарыг Архивын Ерөнхий газраас ирүүлсэн төлөвлөгөөний дагуу жил бүр анхан шатны болон мэргэшүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж байна.

2004 оны улсын үзлэгээр аймгийн Засаг даргын Тамгын газарт илэрсэн зөрчлүүдийг бүрэн шийдвэрлэлээ. Тухайлбал Засаг даргын туслах бичиг хэргийн ажилтан гэсэн хоёр орон тоо нэг байсныг 2 тусад нь салгах, мэдээллийн технологийн мэргэжилтэн шинээр авах, төрийн архивын тасагт гэрээт ажилтан ажиллуулах зэрэг хүний нөөцийн хомсдлыг шийдвэрлэхийн зэрэгцээ байгууллагын архивын Төрийн архиваас тусгаарлан стандартын дагуу тохижуулж, баримтуудыг байршууллаа. / Хэрэгжилт 100,0 хувь/

Өрхийн тариалан эрхлэгчид болон сумдын агропаркийг эзэмшигчдэд хамгаалагдсан хөрсний тариалалтын талаар сургалтыг 16 суманд хийж шинэ техник технологийн холбогдолтой 100 гаруй гарын авлагыг бэлтгэж, өрхийн тариалан эрхлэгчдэд хүргүүлээ. Ногоон хувьсгал үндэсний хөтөлбөрийн шугамаар суурин газрын 7200 айл өрхүүдийг хамруулж, монгол төмс хөтөлбөрөөс 12 сумын үр үржүүлэгч нартай ХХААЖДҮ-ийн газар гэрээ хийж 32.7 га талбайд Герман, Голландын цэвэр 4 сортыг тариалж 182 тн ургац хураан авсан. / **Хэрэгжилт 100,0 хувь**/

Хүн амын боловсролын болон бичиг үсгийн боловсролын түвшний судалгааг 2010 оны хүн амын тооллогоор шинэчлэн гаргахаар төлөвлөж байна. 2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 271 бичиг үсэг үл мэдэгч байгаагаас 52 хүн бичиг үсгийн сургалтад хамрагдаж, эдгээрийн 7 нь бичиг үсэгт тайлагдлаа. /**Хэрэгжилт 100,0 хувь**/

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх сангийн журмыг өөрчлөх төсөл боловсруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бүх зардлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас зарцуулахаар сангийн журамд тусгалаа. /**Хэрэгжилт 90,0 хувь**/

Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан Алдарт эхийн одонтой ахмадуудад олгох тусламж 3185 эхэд 199550 төгрөгийн, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тэтгэмж 1053 хүүхдэд 105300 төгрөгийг олгон ажиллаж байна. /**Хэрэгжилт 90,0 хувь**/

Аймгийн дэд хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж байна. Сум бүрт Морин хуурын дугуйлан ажиллаж 5-8 хүүхэд хамрагдаж байна. Хангайн бүсийн 5 аймгийн уран сайханчдын дунд зохиогдсон уртын дууны уралдаанд тус аймгаас 4 насны ангилалд уртын дуучид оролцон, Дашинчилэн сумын ардын авъяастан Ц.Дондоо тусгай байрын шагнал хүртлээ. Хишиг-Өндөр суманд Морин хуурын бие даасан чуулга байгуулагдах анхны бие даасан тоглолтоо хийлээ. Нутгийн уртын дууг сурвалжлан олох талаар арга хэмжээ авч 3 дууг шинээр сурвалжлан олж бүртгээд байна. /**Хэрэгжилт 100,0 хувь**/

Цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд Баяннуур суманд Солонгосын “Ногоон Ази” ТББ-ын шугамаар мод үржүүлгийн газрыг 23 га-гаар өргөтгөж үхрийн нүд 2100 ширхэг, чацаргана 3150 ш, хайлаас, буйлс, гүйлс, жишд зэрэг нийт 18150 ш, мод бут шинээр тарьснаас гадна 25000 ш, улиасны мөчрийг үржүүлж байна. Мөн 300 м2 –т хүлэмжинд лооль, гинжүү, огурцы, хулуу, тарвас, зэргийг тариалсан байна. Энэ ажлын хүрээнд гүн өрмийн 2 худаг шинээр гаргасан байна. ЗДТГ-ын дэргэд чацаргана, үхрийн нүдний талбай байгуулж орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийг худаг гаргуулж 4.0 сая төгрөгөөр хашаажуулж нийт 1600 ш, мод бут тарьсан байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Айл өрхүүдээс жимсний мод бут тариалах судалгаа авч үхрийн нүд 922 ширхэг, чацаргана 977 ширхэг, байгууллагууд 80 үхрийн нүд, чацаргана 50 тус тус тариалсан ба сумын хэмжээгээр иргэдэд 2029 жимсний мод олгосон байна. Аймгийн хэмжээнд 959.4 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлт, 10 га талбайд ногоон хэрмийн туслах зурвасыг Дашинчилэн суманд байгуулсан.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Малын хашаа хороо барихад чулуу, шавар зэрэг орон нутгийн түгээмэл тархацтай материалыг өргөн ашиглах, малын нөмөр хаалтад зориулан харгана, сөөг, бусад модлог ургамал тарьж ургамлан хашаа барих, малчдыг ой цэвэрлэн гарсан хуурай шургаагаар хашаа хороо барих үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг Орхон, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант зэрэг сумдад хэрэгжүүлж байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

2009 онд Булган, Бугат, Хангал, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр, Рашаант суманд бэлчээрийн менежментийг сайжруулах үүрэг бүхий ТББ байгуулан 145.6 мянган га бэлчээрийг сэлгэх арга хэмжээ авсан. Орхон, Бүрэгхангай, Сайхан зэрэг сум нь ашиглагдаагүй бэлчээрийн талбайг усжуулан /худаг гаргаж/ сүүлийн 2 жил бэлчээрийг хуваарьтай ашиглан хөрсний эвдрэлийг багасгах, байгалийн өөрийн аясаар нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Хялганат тосгонд мод боловсруулах үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар хуулга, савх, шахмал түлш, ислэг хавтан, хавтанцар үйлдвэрлэх үйлдвэр шинээр байгуулагдан ажиллаж 100 хүний байр бий болсон энэ оны 11-р сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Булган хэмжээнд төвлөрсөн халаалтын 10 зуух, объектын 65 зуух ажилладаг. Жилдээ 10 мянган м3 мод хэрэглэж байна. 2009 онд түлш бага хэрэглэдэг зуухаар хангах зорилт тавьж улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн 350.0 гаруй сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Баян-агт, Бүрэгхангай, Баяннуур, Тэшиг сумдын сургууль, Хялганат тосгон сумын цэцэрлэг, дотуур байр зэрэг газруудад шинээр халаалтын тогоо суурилуулж, доторхи халаалтын системийг шинээр угсрах, өөрчлөх ажлууд хийлээ. Аймгийн ЗД-ын 2009-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт модыг түлшинд хэрэглэх явдлыг зогсоох зорилгоор төвлөрсөн халаалтанд шилжүүлэх бодлого баримтлан эхний ээлжинд 2010 онд Хишиг-Өндөр сумыг оруулах талаар холбогдох газруудад санал хүсэлт тавиад байна.

/Хэрэгжилт 70.0 хувь/

Баяннуур сумын иргэн Л. Батсүрэн “Чацаргана” төслөөр 10.0 сая төгрөгний зээлийг аймгийн ЖДҮ-ийг дэмжих “Тусгай зориулалтын сан”-аас зээл авсан байна. Уг зээлийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд төслийн дагуу 2.2 га газрыг хашиж 1100 ширхэг үхрийн нүд, чацарганы суулгацыг Дархан уул аймгийн Ургамал Хамгаалалын хүрээлэнгээс авч тариалсан бөгөөд уг зээлийн 2.0 сая төгрөгийг хашаа барихад, 6000.0 сая төгрөг нь жимсний суулгац авахад зарцуулсан байна. Мөн Баян-агт сум жимс жимсгэний дэд хөтөлбөр боловсруулж газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд жимс, жимсгэнэ тариалах зориулалтаар 25 га тусгаж батлуулсан байна. Хангал сум “Жимс жимсгэнэ”-ийн дэд хөтөлбөр хүрээнд Зэвсэгт хүчний 0234 дүгээр анги 16 га-д чацаргана, Молор Эрдэнэ Түрүү ХХК 6 га-д , II багийн иргэн 1 га-д чацаргана тус тус суулгасан байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Хутаг, Баян-агт, Булган сумдад сургуулийн элсэлт, төгсөлтийн хүүхдүүд нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулаад 3 дахь жилдээ явуулж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх туслах зурвасыг 10 га талбайд, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг 969.4 га талбайд хаврын тарилтыг 75-89%-ийн амьдралттай хийж, гүйцэтгээд байна.

“Цэвэр орчин-Бодит ажил”-ын сарын ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллага бүр 5 ширхэг мод, иргэн бүр 1 ширхэг мод тарих ажилд идэвхи санаачлагатай оролцлоо. Үүний дагуу Аймгийн ИТХ-аар модны жишиг үнийг тогтоолгон албан байгууллага, ард иргэддээ хямд сайн чанарын модоор хангаж ажилласны дүнд 20658 ширхэг мод бут тарьж, 2714.65 м² зүлэгжүүлсэн. Эдгээр мод бутыг тарихад Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй 20 хүн, цэргийн дүйцүүлэх алба хаагчдаас 5 хүнийг аван түр ажлын байраар ханган ажиллуулсан.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудад хамтран ажиллах, Булган Бүтээлч ТББ, Хан-ач гэр бүл ТББ-уудын хооронд зуулчлан тарьц суулгацаар хангах ажлыг зохион байгуулж манай байгууллагаас арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мод бут тарьж ургуулах арчилах гарын авлага гарган байгаль хамгаалагч болон бусад холбогдох аж ахуй нэгж хүмүүст тараасан. Мод үржүүлгийн газарт улиасны мөчир 2000 ширхэг, улаан бургасны мөчир 4000 ширхэг, чацарганы 3300 ширхэгийг мөчрийг тарьсан.

/Хэрэгжилт 100.0 хувь/

ЖДҮДС-д улсын төсвөөс 565,0 сая, орон нутгийн төсвөөс 130,0 сая, арилжааны банкнаас 208,5 сая төгрөг нийт 903,5 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж орон нутагт хөгжүүлэх үйлдвэр үйлчилгээний чиглэлийн дагуу санд ирүүлсэн 170 гаруй төслүүдийг хэлэлцэж 87 төсөлд 100 хувь олгоод байна.

/Хэрэгжилт - 100.0 хувь/

Тогтоолын заалтын дагуу 2005 онд Засаг даргын захирамжаар журамдаа нэмэлт өөрчлөлт оруулсныг мөрдөж байна. Өнгөрсөн онд аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагууд иргэдээс 7696, түүний дотор аймгийн Засаг даргын тамгын газар амаар 86, бичгээр 2008 өргөдөл хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгууллаа. Иргэдийн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар төв орон нутгийн хэвлэлээр 3 удаа мэдээлсэн. Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар гаргасан хууль, тогтоол, захирамж журмын хэрэгжилтийг сум, байгууллагад зөвлөх арга хэмжээ авч ажилласан

Сум, байгууллагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж хэвшээд байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Сум, агентлагууд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хөндөгдсөн асуудлуудыг бодлого шийдвэр, авах арга хэмжээнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргын тамгын газар иргэдийн өргөдөл хүсэлтэд хөндөгдсөн асуудлын дагуу бодлого шийдвэр, үйл ажиллагааны төлвөлөгөөнд тусгаж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсний үндсэн дээр өнгөрсөн онд 30 орчим иргэнд гэр олгох, нийтийн эзэмшлийн 3 байрны дээврийг засварлах, аймгийн төвийн үерийн далан, халаалтын шугам сүлжээний ажлын явцад үүссэн чулуу шорооны үлдэгдлийг цэвэрлэж хөрсжүүлэх зэрэг ажлыг зохион байгууллаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн мэдээ тайланг 4 удаа хүлээн авч нэгтгэн дүгнэлт хийж ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын тамгын газарт хүлээн авсан иргэдийн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлийн мэдээ тайланг гаргахдаа хөндөгдсөн асуудлын харьцаа, өсөлт бууралт, түүний шалтгаан, өргөдөл хүсэлтийг шийдвэрлэхээр авсан арга хэмжээ, хөндөгдсөн асуудлыг бодлого шийдвэрт хэрхэн тусгасан зэргийг нарийвчлан тусгасан. 2008 онд ЗГХЭГ-аас 1, УИХ-ын гишүүдээс 10 өргөдөл шилжүүлэн ирүүлснийг хэрэгжүүлэх арга хэмжээ зохион байгуулж хариуг өгсөн.

Хэрэгжилт

100.0 хувь/

Өнгөрсөн онд НӨУЕ-ны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар аймгийн Засаг даргын тамгын газарт иргэдээс өргөдөл ирүүлээгүй.

/Хэрэгжилт

100.0 хувь/

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөлийг 2009 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 100 тоот тогтоолоор байгуулан дүрэм, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлж эхэллээ. Мөн сумдад салбар зөвлөл байгуулан ажиллуулж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Улсын МХГ, СХЗТ хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа давхардсан лабораториудад 2007 онд атестатчилал хийсэн. Химийн сорилт шинжилгээний 2 лаборатори үйл ажиллагаа явуулж байна.

/Хэрэгжилт - 70.0 хувь/

Орон нутгийнхаа түүхий эд, нөөцөд түшиглэсэн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, зээл хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээ бий болгох, сурталчлах, зарим бүтээгдэхүүнийг экспортонд гаргахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг зонхилж хэрэгжүүллээ. 10 сумын брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, зориулалтын ажлын байранд ажил үйлчилгээг явуулах нөхцөл боломжыг бүрдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх зорилгоор 150,0 гаруй сая төгрөгний хөнгөлттэй зээл олгож "Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээ" сэдэвт танилцуулганд оруулах 9 брэнд бүтээгдэхүүний танилцуулгыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороонд хүргүүллээ. Энэ онд Намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээнд зээл авсан аж ахуйн нэгж иргэд брэнд бүтээгдэхүүнээрээ оролцож Могод сумын айраг "Үнэмлэхүй шилдэг бүтээгдэхүүн" 3 жилийн хугацаатай батламж, Цөм сүргийн үржлийн төвийн нарийн нарийвтар ноост Хангай үүлдрийн хонь "Шилмэл мал-2009" Алтан медаль хүртэж, Сайхан сум зохион байгуулалт сайтай оролцсон байгууллага, "Булган Ундарга" ХХК-ны жимс, жимсгэнэ бүтээгдэхүүн Хангайн бүсийн 2009 оны "Экологийн цэвэр бүтээгдэхүүн"-ээр шалгарлаа.

/Хэрэгжилт -100,0

хувь /

"40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Булган суманд 30 айлын орон сууцыг шинээр ашиглалтанд оруулж, холбогдох журмын дагуу иргэдэд орон сууц олгох ажлыг зохион байгууллаа. 2009 оны 12 дугаар сарын байдлаар орон сууц олгох журмын дагуу 12 айл тухайн орон сууцанд ороод байна.

/Хэрэгжилт 100,0 хувь /

Булган суманд шинээр баригдах төрийн албан хаагчдад зориулсан 20 айлын орон сууцны барилгын газрын асуудлыг шийдвэрлэлээ. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журмын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж Нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг нийт иргэдийн мэдээллийг 2009 оны 03 сараас эхлэн мэдээллийн нэгдсэн баазад оруулан ажиллав. Одоогийн байдлаар мэдээллийн нэгдсэн баазад 16637 иргэн болон хүүхдийн мэдээлэл нэгтгэгдээд байна. 2009 оны 09 сараас эхлэн Халамж үйлчилгээний программ “ХҮМ”-аар халамжийн тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн тэтгэмж, шинэ гэр бүлд олгох нэг удаагийн тэтгэмжийг олгож эхэлсэн. Бүх сумдын ХХҮ-ний мэргэжилтнүүдэд ажлын шаардлагын дагуу хамгийн сүүлийн үеийн технологийн зөөврийн гар компьютер болон принтерээр хангаж өгсөнөөр ажлын үр дүн сайжирч Хүүхдийн мөнгөн тэтгэмж олголтонд хяналт тавих нөхцөл боломж бүрдэн ажиллаж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Аймгийн Засаг даргын захирамжаар " Өсвөр үеийн шигшээ баг" байгуулах дүрмийг боловсруулан аймгийн хэмжээнд бөх, тэшүүр, цана, бокс, шатрын чиглэлээр шигшээ баг тогмтол хичээллэж байна.Биеийн тамир спортын талаар 2009-2012 онд баримтлан ажиллах бодлогыг боловсруулан гаргаж,бодлогын зорилтын хүрээнд өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээнүүд тусгагдан ажиллаж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Хангайн бүсийн 2009 оны ажлын төлөвлөгөөнд нийгмийн салбарын 4, дэд бүтцийн салбарын 2, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 1 нийт 7 объектийн саналыг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн бүсийн зөвлөлд хүргүүлсэн. Монгол улсын эдийн засаг нийгмийг 2010-2015 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл баталж байгаатай холбогдуулах дахин 7 төслийн саналыг бүсийн зөвлөлд илгээж нийт 2 удаа давхардсан тоогоор 13 төслийг төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүллээ.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Уг тогтоолыг хэрэгжүүлэхээр Сангийн сайдын тушаалаар 2007 оноос улс орон нутгийн төсвийн байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцож санхүүгийн тайланд тусгаж байгаа бөгөөд 2009 оны эхний хагас жилээр улс орон нутгийг төсвийн байгууллагын үндсэн хөрөнгөнд 516148,6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож нийт хуримтлагдсан элэгдэл 8733509,6 мянган төгрөг болсон байна.

/ Хэрэгжилт 100.0 хувь/

Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн, Нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн хүрээнд ХХҮ-ний мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 3 шатны сургалт, "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх", "Халамжийн хууль"-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор 5 өдрийн сургалтыг ХХҮГ-тай хамтран зохион байгуулж сумдын ХХҮ-ний мэргэжилтнүүдийг 100 хувь хамруулсан. НХХЯ, ОУ-ын шилжин суурьшлын байгууллага, БСШУЯ, Нийгмийн ажилтнуудын багш сургагчдын холбоо, Юнисефээс хамтран зохион байгуулсан "Хүүхэд хамгааллын асуудал болон хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сургалтанд оролцлоо. Сургалтанд оролцогчид "Хүүхэд хамгааллын үндсэн ойлголт", "Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлж, хохирогчдод нийгмийн үйлчилгээг үзүүлэх нь" үндсэн сэдвүүдээр чадавхижлаа. Сургалтын үеэр "Хүүхэд эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхээр зохион байгуулж буй ажлын туршлага" мэдээллийг оролцогчдод хүргэлээ.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй архины "Булган спирт" ХХК, "Шинэ иэнгис" ХХК-ны үйлдвэрүүдэд оны эхнээс батлагдсан графикайн дагуу улирал бүр дээж аван хяналт тавин ажиллаж байна. Мөн тусгай зөвшөөрөл бүхий худалдаа үйлчилгээний цэгүүдэд энэ оны аттестатчилал хийж 20 цэгийн эрхийг хасах, 10 цэгийн эрхийг 3 сар хүртэл хцгацаагаар эрхийг нь түдгэлзүүлээд байна. /

Хэрэгжилт 90.0 хувь /

Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд шилжүүлэх техник хэрэгсэл хангалттай болсон. Музейн үзмэрийн 85 хувийг зурагжуулж компьютерт оруулаад байна. Мөн сумдын Орон нутгийг судлах кабинет хөдөө орон нутагт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг хийж зургийг аван компьютерт оруулсан. Мөн нэгдсэн програмд холбогдон маягт-2-оор бүх үзмэрээ бүртгэсэн. Гэрэл зургийн лаборатортой болсон.

/Хэрэгжилт 100 хувь /

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтэнд тусган ажиллаж байна.Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна.2010 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн хүрээний мэдэлд тусгасан.

/Хэрэгжилт 90.0 хувь/

2008 онд манай аймаг "Бөөний худалдааны сүлжээ" төслийн 2 дахь үе шатанд хамрагдаж төслийн гүйцэтгэгчээр "UFS Булган Өсөх" ХХК шалгарч аймгийн төвд хүнс өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны төв байгуулж үйл ажиллагаа нь жигдэрч чанар сайтай өргөн сонголт бүхий бараа бүтээгдэхүүнээр үйлчилж байна.

/Хэрэгжилт - 100,0 хувь/

2009 онд Аймгийн ИТХТ-ийн хурлаар “ Хүүхдийн хөгжил хамгааллыг 2009-2012 онд сайжруулах үндсэн чиглэл”-ийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх, төслийн жагсаалтад оруулан Хүүхэд хөгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гарган мөрдөж ажиллаж байна. Оны эхний хагас жилд “Цодгор хүү -2009” “Уран жиргээ -2009” “Өсвөрийн шилдэг дуучин бүжигчин -2009” “Анли хэл бидний хэл “ “ Замын хөдөлгөөний цагаан толгой” Хүүхдийн төлөө хэлтсийн нэрэмжит шилжин явах цомын төлөө гар бөмбөгийн “Чансаа-2009” Хүүхдийн ертөнц зэрэг 10 гаруй төрлийн урлаг спортын тэмцээнүүдийг зохион байгуулж 17 сумын 600 гаруй хүүхдүүд хамрагдсан байна.

Баг хамт олноор ажиллах чадварыг дээшлүүлэх, амьдрах ухаанд сургах зорилгоор «Майхант зуслан-хүүхдийн солонго урлагийн наадам » арга хэмжээг 2009 оны 6 сарын 20-25-ны өдрүүдэд Булган аймгийн Хангал сумын Галтайн амралтын бүс нутагт зохион байгууллаа. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Орон нутгийн хөгжил дэвшилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах зорилгоор Жендерийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сум нутагт зохион байгуулж байна. Аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Манлайлагч эмэгтэйчүүд” чуулга уулзалтыг зохион байгуулж, “Аймгийн эмэгтэйчүүдийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай” ЗД-ын илтгэл, эмэгтэйчүүд –эрүүл мэнд, хүүхдийн хөгжилд эцэг эхийн үүрэг, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал-хөдөлмөр эрхлэлтийг өнөөгийн байдал зэрэг 5 дэд илтгэл хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч, 9-н “Тэнгэрлэг гэр бүл” –ийг шалгарууллаа. Хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлыг авч үзвэл боловсролын салбарт ажиллагчдын 84.0 хувь нь, эрүүл мэнд нийгмийн халамжийн салбарт ажиллагсдын 87.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг авч үзвэл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 28.5 хувь, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 20.0 хувь, сумын ИТХ-ын дарга нарын 6.2 хувь, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 37.5 хувь, сумын ИТХ-ын төлөөлөгчдтэй оролцсон байгууллага, “Булган Ундарга” ХХК-ны жимс, жимсгэнэ бүтээгдэхүүн Хангайн бүсийн 2009 оны “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”-ээр шалгарлаа.

/Хэрэгжилт -100,0 хувь /олно.Мод бэлт

Тогтоолоор батлагдсан босго үнийг баримтлан орон нутагт Бараа ажил үйлчилгээний сонгон шалгаруулалт явуулан хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд Сангийн сайдын 2007 оны 04-р тушаалыг сум байгууллагуудад хүргүүлж аймгийн худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гаргаж биелэлтийг зохион байгуулан Засгийн худалдан авах ажиллагааны босго үнийг мөрдлөг болгон ажиллаж байна

/Хэрэгжилт 100.0 хувь/

ТБУСТХуулийн дагуу 2008 оны Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг тогтоолын 1 хавсралтаар батлагдсан бүтээгдэхүүний ерөнхий ангийг баримтлан гаргаж Сангийн яаманд хүргүүллээ.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн "Экологийн цэвэр бүтээгдэхүүн" дэд хөтөлбөр боловсруулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг салбар бүрээр тодорхойлж, тэргүүлэх чиглэлийг тогтож ЖДҮДС- гаас хөнгөлттэй зээлээр дэмжиж байна. "Алтан намар -50" үзэсгэлэн худалдаа зохион байгуулж экологийн цэвэр бүтээгдэхүүнүүдээ шалгаруулж шагнаж урамшууллаа. Хангайн бүсийн түншлэл -2009 үзэсгэлэн худалдаанаас "Булган Ундарга" ХХК -ны савласан жимс жимсгэнэ бүтээгдэхүүн "Экологийн цэвэр бүтээгдэхүүн"-ий шагнал хүртэж, Могод сумын айраг ХХААХҮЯ -наас "Үнэмлэхүй шилдэг бүтээгдэхүүн 3 жилийн батламж", Хангай үүлдрийн хонь, Сэлэнгэ үүлдрийн үхэр "Шилмэл мал -2009" арга хэмжээнээс алт, мөнгөн медалууд хүртлээ. Цаашид аймгийнхаа дотоодын нөөц боломжид түшиглэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүнүүдийг бүс улсын хэмжээнд баталгаажуулж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар шинэ нэр төрлийг бий болгож, Газарзүйн заалттай брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг бий болгох зорилт тавин ажиллаж байна.

/Хэрэгжилт -

100.0 хувь/

Аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шинижлгээ хийх журмыг мөрдөж ажиллаж байгаа бөгөөд сумдын Засаг дарга нарын үйл ажиллагаанд хяналт шинижлгээ хийх журмыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан мөрдөж ажиллаж байна. Засгийн газрын 51-р журмыг өөрчилөх нэмэлт өөрчилөлт оруулах чиглэлээр Засгийн газарт жил бүр саналаа уламжилдаг бөгөөд цаг үеийн шаардлагаас болж зарим нэг заалтыг өөрчлөх шаардлага урган гарч байна. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Сангийн сайдын тушаалаар журмын дагуу батлагдсан төсвийг зардал хооронд гүйлгэн зарцуулах боломжтой болсноор төсвийн тогтмол зардлаас бусад зардлын хувьд өргүй гарах боломжтой байгаа. Орон нутгийн өмчит дулааны "Булган Мээж" ХХК нь 2010 оны 10 сарын 01-нээс эхлэн дулааны үнээ үнээ нэмж 1 м3 халаалтын үнэ 990 /НӨАТ-тай/, цэвэр усны үнэ 2392,50 /НӨАТ-тай/, бохир ус /НӨАТ-тай/ 2288 болгосноор зарим төсвийн байгууллагууд тогтмол зардлын өртэй гарах тооцоотой байна.

/Хэрэгжилт 80.0 хувь/

Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу төсвийн зардлын зүйл тус бүрт Төрийн сангийн урсгал хяналт тавьж ажилласнаар батлагдсан төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан байдал гараагүй байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Засгийн газрын удирдлага мэдээллийн системд холбогдсоноор төсвийн багцын дотоод хяналт сайжирч байна. Улс орон нутгийн байгууллагын төсвийн эрхийг батлагдсан төсвийн дагуу үүсгэж, төсөв зарцуулагдаж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэхдээ цалин, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардлууд, бусад зардал гэсэн дарааллын дагуу олгож, санхүүжилтийн хуваарийг оновчтой тогтоох замаар эх үүсвэрийг чөлөөлж үйл ажиллагааг хэвийг явуулах нөхцөл бололцоог хангаж ажиллаж байна.

/ Хэрэгжилт 100,0 хувь/

Төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас бүтэн жилээр гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж ажиллаж хэвшлээ.

/Хэрэгжилт-100,0 хувь/

Төрийн архивт мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн архивын 152 хөмрөгийн байнга болон түр хадгалагах баримтын дансыг компьютерт оруулаад байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд 2 удаа сургалтанд хамрагдсан. Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх, мэдээллийн технолги нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг Даргын Тамгын газарт албан хэрэг хөтлөлтийн бүртгэл хяналтын программ 1.500.000 төгрөгөөр суулгаж, сургалт зохион байгуулав.

Мөн Төрийн архивт 500.000 төгрөгийн засвар хийж, 4320000 төгрөгөөр 9 нягтруулсан тавиур авч, 126 хөмрөгийн 4915 баримтыг байрлууллаа. Мөн канон, компьютер, скайнер тус бүр 1 ширхэгийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Рашаант суманд Хадад хошуу, Элсэн тасархай, Эрдэнэ хамбын хийд, Бүрэгхангай сумын Бодь мод, Бугат суманд Саадаг өлгүүр, Хөх чулуут, Хишиг-Өндөр суманд Сантын эх, Баян-Агт суманд Саахарын рашаан, Их булгын рашаан, Халтрын буган чулуу, Шар баг, Шивээт улааны цогцолбор, Могод сумын Асгатын хиргисүүр зэрэг дурсгалт газруудыг сэргээн тохижуулж тэмдэгжүүлэлт хийсэн.

/Хэрэгжилт 100.0 хувь/

" Эрүүл Монгол Хүн" аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан гаргаж, хөтөлбөрийн хүрээнд нийт хүн амын 90%-ийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулан, өвчтэй илрэгсэдийг эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Нийт 24000 хүнийг эрүүл мэндийн мэдээллийн цахим санд бүртгэсэн. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлд баримлах бодлого боловсруулан ажиллаж байна. Хойд бүсийн сумдын үхэр сүрэгт Сэлэнгэ үүлдрийн хээлтүүлэгчийг ашиглах аймгийн Засаг даргын 2009 оны 152 тоот захирамж гаргалаа. Мал сүрэгт үзлэг ангилалт явуулж Бугат, Бүрэгхангай, Могод, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр сумдын 76501 хонь, 38213 ямаа нийт 114.7 мян бог малд ангилалт хийж, 8.0 мян хонь, 3.2 мян ямаагаар цөм сүрэг бүрдүүллээ. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжүүлэх, өндөр ашиг шимтэй малын нийт мал сүрэгт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Булган сумдад бод малын пункт ажиллуулж, Казакын цагаан толгойт, Алатау, Хар тарлан үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр үхэр сүргийн хээлтүүлгийн ажлыг зохион байгууллаа. Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Мянганы хөгжлийн сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа “Хот орчмын бэлчээрийн төслийн хүрээнд Хангал, Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Орхон, Сэлэнгэ сумдад 56 эрчимжсэн аж ахуй байгуулахаар өрхөө сонгоод байна. Энэ чиглэлийн аж ахуй нэгжүүдийг сонгон шалгаруулж аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хөнгөлөтэй зээл олгож байна. Аймгийн хэмжээнд Сэлэнгэ, Хангал, Бугат, Булган сумдад шинээр 7 үхрийн болон гахайн фермерийн аж ахуй байгуулагдсан байна. ХХААХҮЯ, НХХЯ-ны хамтран хэрэгжүүлж байгаа “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд Гурванбулаг, Могод, Хутаг-Өндөр сумдаас 30 малчин өрхийг сонголоо. Мөн ДЗОУБ-аас тус аймагт хэрэгжиж байгаа орлого багатай малчин өрхүүдийг сонгон малжуулах төсөлд булган сумаас 21 өрх, Сэлэнгэ, Хангал, Орхон, Хишиг-Өндөр сумдаас 50 гаруй өрх хамрагдаж, Дашинчилэн суманд үхрийн фермерийн аж ахуй байгуулагдлаа.

Хэрэгжилт 100.0 хувь/

Химийн хорт бодисын тооллогыг Монгол Улсын Их Сургуулийн Биологийн Тэнхимийн сургуулийн 3 дугаар курсын 4 оюутнуудтай хамтран, мөн Сумдын Байгаль орчины Улсын байцаагч ,байгаль хамгаалагч нартай хамтран хиймийн хорт бодисын тооллого хийж БОЯаманд хүргүүлэв.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Байгалийн гамшгийн улмаас орон гэргүй болсон иргэдэд гэр орон сууц авахад нь зориулж тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх, гэр оронгүй иргэдэд гэр өгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар сумдад 30 гэр олгоод байна. Дэлхийн зөн ОУБ-ын Булган нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 6 өрхөд гэр олголоо. Булганхангай нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс 5 иргэнд гэр олгож, Дашинчилэнд 14, Бүрэгхангайд 6, нийт 20 өрхийг байшинтай болголоо.

Хэрэгжилт 100.хувь/

Сумдын ахмадын болон ХБИ-ийн төлөллийг Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулан ажиллаж “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр” хэрэгжүүлж, хөтөлбөрт хамрагдах өрхүүдийн судалгааг хийж, төвд явуулан сонголт хийлгэснээр нийт 338 өрх хамрагдаж, эдгээр өрхөд хүнсний бүтээгдэхүүн авах /14.000 т/ 11.12 сарын тасалбарыг олгоод байна.

Аймгийн ЗД-аас дэмжлэг үзүүлж сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, сумдын удирдлага, нийгмийн ажилтнуудад “ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН ГЭР БҮЛИЙН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА, ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ”, “ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” сэдвээр Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганатад бүсчилсэн сургалт хийлээ.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Орон нутгийн амралт, рашаан сувиллын газарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үнээр амруулж сувилуулах, иргэдийг төрөлжсөн асрамжид хамруулахдаа аймгийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн саналыг үндэслэн шийдвэрлэж байна. Аймгийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтсийн дэргэдэх Ахмадын зуны амралтыг 6- 8-р сард 8 ээлжинд 160 ахмадуудыг амрааж, одоо өвлийн амралтанд 3 дахь ээлжээ авч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрөлжсөн асрамж, сувилалд хамруулах ажлыг ХХҮХ-ийн судалгаа , тэдний саналд тулгуурлан үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.Нийгмийн халамжийн үйлчилгээг өргөтгөх зорилгоор Ахмадын амралт болон Хүүхдийн сувилалыг тогтмол ажиллуулж ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу өрхийн хүүхдүүдэд халамжийн үйлчилгээг үзүүлэн хэлтсийн харьяа Хүүхдийн сувилалын яслид эхний 11 сарын байдлаар өдөрт 38-40 хүүхэд аван ажиллаж байна.

/Хэрэгжилт 90.0

хувь/

Төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагууд ажиллаж байсан ахмадуудаа жил бүр хүлээн авч хүндэтгэл үзүүлж тэдэнд дэмжлэг тусламж өгч ажиллаж байна. "Ахмадын сан" байгуулах тухай Аймгийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 14 тоот захирамж гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна. Сумдын Засаг дарга нар захирамж гарган Ахмадын сан байгуулан журам гарган ахмадуудын нийгмийн хамгааллыг сайжруулахад зориулан зарцуулж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Сумын бүртгэл мэдээллийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн нийгмийн ажилтны чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод нэмж оруулан зохион байгуулалтын арга хэмжээг авч Бүртгэл мэдээлэл-нийгмийн ажилтан сум бүрт ажиллаж байна. /Хэрэгжилт 90,0 хувь/

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтэнд тусган ажиллаж байна.Хөтөлбөрийн хүрээнд 3000 хүнийг нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, 2400 хүнд эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийж, 5 суманд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийсэн.Хишиг-өндөр сумын шүдний эмчийг мэргэжүүлэх сургалтанд хамруулсан. /Хэрэгжилт 100,0 хувь/

Хөдөлмөр эрхлэлтийн талаар аймгаас баримтлах бодлогыг батлуулан, хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлт ажилгүйчүүдийн бүртгэлд 2009 оны 11 сарын байдлаар 2392 хүн бүртгэгдснийг ажилд зуучлах, байнгын болон улирлын байраар хангах арга хэмжээг авлаа. Үүнд: Ажил олгогчдоос ирүүлсэн 868 ажлын байрны захилгад 621 хүнийг зуучлан, шинээр бий болгосон байнгын ажлын байранд 673 хүнийг, улирлын ажлын байранд 259 хүнийг ажлын байраар хангаж, ажил идэвхитэй эрж хайж байгаа нийт хүний 64.9 хувийг нь хөдөлмөр эрхлүүллээ. ХХҮХ-т бүртгэлтэй иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа ажил олгогчтой гэрээ байгуулан ажил олгогч эздийг дэмжих ажлыг орон нутагт сурталчилан зохион байгуулж, 13 хүнийг ажлын байраар хангасан 7 ажил олгогчид 9.4 сая төгрөгний нөхөн олговор олгож урамшууллаа. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Могод, Сэлэнгэ сумдын 30 малчин өрх хамрагдлаа. Эдгээр өрхүүд нь аж ахуй эрхлэлтийн үйлдвэр дээрх сургалт, зээлийн үйлчилгээ, малжуулах үйл ажиллагаа, ажил олгогчийг дэмжих, туршлага солилцох, үзэсгэлэн худалдаа зэрэг үйл ажиллагаанд хамрагдаж, 70 шахам сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ. Дэлхийн зөн ОУБ-ын Булган нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс малжуулах төсөл хэрэгжүүлж Булган сумын 21 өрхөд 840 мал, Хангал, Хялганат, Орхон, Хишиг-Өндөр сумын 28 өрхөд 1120 мал олголоо. Мөн Булган хангай нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс малжуулах төсөл хэрэгжүүлж 100 өрхөд 2850 гаруй мал олгосон байна. /

Хэрэгжилт 90.0 хувь/

Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг сум байгууллага, агентлагуудад хэрхэн зохион байгуулж байгаад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд журамд заасны дагуу улирал бүр ЗГХЭГ-т тайлагнаж байна. Сумдын ЗДТГ-т уг журмыг хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг чиглэл өгсөн бөгөөд аймгагт мөрдөж ажиллах журам гаргахаар санал аваад байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Одоогоор албан ёсоор мах бэлтгэн нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байхгүй. Орхон аймгийн "Эрдэнэт прогресс" ХХК -тай гэрээ байгуулан 2 сарын хугацаанд хямд үнэтэй эрүүл ахуйн шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүн нийлүүллээ."Хутаг -Өндөр мах маркет" ХХК хөргөлтийн тоног төхөөрөмжийг шинэчилж аймгийн төвийн хүн амд хагас боловсруулсан дайвар бүтээгдэхүүн нийлүүлэхээр бэлтгэж байна. Үйлдвэрийн орчинд бэлтгэсэн мах махан бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх бодлогоор аймгийн төвд мал мах бэлтгэх нэгдсэн цэг хөргүүртэй зоорь барих бизнес төсөлд 50,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлж үйлдвэрийн барилга угсралтын ажил 90,0 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Булган суманд шинээр баригдах төрийн албан хаагчдад зориулсан 20 айлын орон сууцны барилгын газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлээд байна.

/Хэрэгжилт 100,0 хувь /

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний ажлын хүрээнд нийт шалгасан тээврийн хэрэгсэл-2001, үүнээс илрүүлсэн зөрчил-387, гарал үүслийн гэрчилгээгүй мал мах тээвэрлэсэн-57 толгой мал, мөн гарал үүслийн гэрчилгээгүй хөлөөр нь тууж явсан нийт-648 толгой мал, тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн 1522 толгой малын мах зэргийн шалган зөрчлийг засуулах арга хэмжээг авч 1.634.000 төгрөгийн торгуулийг оногдуулсан байна. Гарал үүслийн гэрчилгээгүй холбогдох хууль тогтоомжуудыг зөрчсөн 9 хэргийг холдбогдох газарт нь материалжуулан шийжүүлсэн байна.

/ Хэрэгжилт

100.0 хувь /

Аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас гарсан аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу устгаж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

“ Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2 дугаар үе шатны төсөл ”-ийн хүрээнд 1340 метр газарт бохир ус зайлуулах хоолой шинээр угсарч, бохирын 29 худаг шинээр барьж, улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

2009 онд аймгийн хэмжээнд 100 толгой загас барих зөвшөөрөл олгогдсоны дагуу төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн.

/Хэрэгжилт 100,0 хувь /

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж , түүнд тусгагдсан асуудлыг Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган залуучууд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж байна.Хөтөлбөрийн хэрэгжилтийг гарган хяналт шинжилгээ үнэлгээ хийж удирдах дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусгах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглан санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авч 2009 онд Аймгийн ИТХТ-ийн хурлаар “ Хүүхдийн хөгжил хамгааллыг 2009-2012 онд сайжруулах үндсэн чиглэл”-ийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн зорилт, зорилго хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сумдын ЗДТГ, ЕБС-ийн нийгмийн ажилтан, хүүхэд, залуучуудын ТББ-ын идэвхтэн сонгуультан, холбогдох хэлтэс, агентлагийн ажилтнуудыг оролцуулсан сургалт, семинар зохион байгуулж тодорхой аргачлал, гарын авлага, материал өгөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль хяналтын байгууллага, ТББ, төсөл хөтөлбөрийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулж байна.“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн тайланг гарган Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сумдын Засаг даргын тамгын газар, холбогдох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тодорхой чиглэл өгч хэрэгжүүлээ.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан түүнд шаардагдах зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 258 байгаа бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамт олны нь дунд сургах, төлөвшүүлэх талаар ярилцлага явуулж “Хариу нэхээгүй тус” аян зохион байгуулж өөрт илүүдэлтэй байгаа эд зүйлсийг цуглуулах, хичээл сургалтанд нь туслах, хэвтрийн өвчтэй иргэдэд гэрийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг жил бүр уламжлал болгон явуулж энэ арга хэмжээнд 60 хүн хамрагдлаа. Хөгжлийн бэрхшээлтэй 80 гаруй хүүхдэд нөхөн сэргээх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сумдын Засаг даргын тамгын газар, холбогдох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тодорхой чиглэл өгч ажиллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөрийн явцын тайланг гаргаж хугацаанд нь НХХЯ-д хүргүүлэн ажиллаж байна.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 192 тоот тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг батлан гаргаж хэрэгжүүлтийг зохион байгуулан ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болгосон. Үүний хүрээнд жил бүр хийгдэх ажлын аймгийн төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтийг зохион байгуулан 2009 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хамт гарган ажиллаж байна.

/ Хэрэгжилт 100.0 хувь /

Аймгийн ахивын тасгийг 2007 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ээс салгаж ХЗХ-ийн бүтцэд оруулан зохион байгуулсан бөгөөд шаардлагатай байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байна. Аймгийн Архивын тамгийн тавиурыг тайлант онд өөрчилж шинэчилэн, өрөөг тохижуулан шаардлагатай техник хэрэгслээр хангаж ажиллаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт 2009-2012 онд баримтлан ажиллах бодлогыг гарган, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллалаа. Хөтөлбөрийн чиглэлээр 3 суманд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, сургалтыг зохион байгуулан 300 гаруй хүнийг хамруулсан.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Манай аймагт иоджуулах давсны зориулалтаар ашигладаг газар байхгүй байна. Харин малын тэжээл дэд хөтөлбөрт хамрагдсан Хангал сумын Сумын ного хоршоо, Сэлэнгэ сумын Ургацын түрүү хоршоод иоджуулсан малын тэжээл үйлдвэрлэж байна. Хүнсний хэрэглээнд 100 хув иоджуулсан давс хэрэгжүүлж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Монгол улсад газар тариаланг бие даасан салбар болгож хөгжүүлсэний 50 жилийн ойг угтаж 2 жилийн бүтээлч ажил зарлаж хэрэгжилтийг 12 сарын 18 нд дүгнэлээ. 2009 онд “Атрын III аян” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажилласанаар аж ахуйн нэгж иргэдийн эзэмшилд байгаа 65.0 мянган га эргэлтийн талбайн 58.5 мянган га талбай эргэлтэнд оруулж эргэлтийн талбайн 92 хувийг ашиглаж, 27249 га талбайд үр тариа, 875,5 га талбайд төмс, 300 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 30291 га талбайд уринш бэлтгэж өмнөх жилээс 4,0 мянган га-аар илүү, усалгаатай тариалангийн хэмжээг 1736 га-д хүргэж, инженерийн хийцтэй усалгааны систем ашиглалтанд орж 676 га-д усалгаатай үр тариа тариаллаа.

Аяны хүрээнд техникийн шинэчлэл хийгдэж өндөр хүчин чадалтай 28 трактор, 7 комбайн болон 86 чиргүүл дүүжин машиныг ургац хураалтанд ашиглаж, техникийн паркийн 30 гаруй хувийг шинэчилж, өрхийн тариаланчдад үйлчлэх техникийн дундын үйлчилгээний парк байгуулагдсан.

2009 онд 48057 тн буюу нэгжээс 18.3 цн, төмс 8113 тн буюу нэгжээс 92.5 цн, хүнсний ногоо 2932.4 тн буюу нэгжээс 97.7 цн ургац хураан авч, аймгийн нийт хүн амын гурилын хэрэгцээг 150 хувиар, төмс 130 хувиар, хүнсний ногоог 70 хувиар хангахаар тооцоо гарч сүүлийн 8 жилд хураан аваагүй ургацыг авсан өндөр амжилт гаргасан.

Нийт хураан авсан ургацаас улсын үрийн нөөцөд 3500 тн, Тариалан эрхлэлтийг дэмжих санд 17000 тн, дотоодын гурилын үйлдвэрүүдэд 7000 гаруй тн-ыг тушааж, үрэнд 5100 тн нөөцөллөө.

/ Хэрэгжилт 100.0 хувь/

2006 онд аймгийн Аудитын шалгалт хийгдэж, 13 116 600 төгрөгийн акт тогтоосоноос 2007 онд нийт 5226480 төгрөгийг барагдуулсан бөгөөд өртэй байгаа зарим сумдын нарны цахилгаан үүсгүүрийн эргэн төлөлтийг хийхийг шаардаж, үүрэг өгч ажилласан. Эдгээр үнийн дүнгээс одоогоор Сэргээгдэх эрчим хүчний төвийн дансанд хэд нь тушаагдсаныг аймаг мэдэх боломжгүй болсон.

/Хэрэгжилт 40,0 хувь/ ХАСАХ САНАЛТАЙ БАЙНА

Иргэний бүртгэл мэдээллийн ажилтнууд сумын ЗДТГ-т "Иргэний бүртгэл нийгмийн ажилтан" гэсэн ажлын байран дээр аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгонд иргэний бүртгэл хариуцсан ажилтнуудтай.

/Хэрэгжилт 100,0 хувь/

ХАСАХ САНАЛТАЙ БАЙНА

Иргэний бүртгэл хариуцсан ажилтнуудын 90 хувь нь компьютер техник хэрэгслээр хангагдсан байна.

/Хэрэгжилт

90,0 хувь/ ХАСАХ САНАЛТАЙ БАЙНА.

Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд өнгөрсөн онд Хангал, Хутаг-өндөр, Бугат сумдад улс, аймаг, цэргийн цолгүй залуу бөхчүүдийн барилдааныг зохион байгуулж, 100 гаруй хүнийг хамруулсан.Сурын спортыг аймгийн хэмжээнд Бүрэгхангай сумын тамирчдыг түшиглэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаагаас гадна Орхон аймгийн Хангарьд клубтэй гэрээ байгуулан ажиллаж байна.2009 онд Булган аймгийн морин спортын холбоог шинэчлэн байгуулсан.

/Хэрэгжилт 90.0 хувь/

“Жендерийн тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын 184 дүгээр захирамжаар баталгаажуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Сумдын Засаг даргын тамгын газрын асуудал эрхэлсэн ажилтны семинарыг жил бүр зохион байгуулж тэдэнд гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл боловсруулж хүргүүлж байна.

2009 оны эхний хагас жилд ХЯБХ-ийн “Эмэгтэйчүүд хөгжил” дэд хэсгийн бичил санаачлагыг дэмжих “Бичил зээлийн чиглэлээр Өөртөө туслах бүлэг” байгуулах сургалтыг нийт 16 сум 1 тосгонд зохион байгуулж 550 гаруй эмэгтэйг хамрууллаа.

Мөн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах тэднийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, “Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам “ сэдвүүдээр Орхон, Баяннуур, Могод, Сайхан, Хишиг-Өндөр, сумдад зохион байгуулж нийт 200 гаруй эмэгтэйчүүдийг сургалтанд оролцуулав.

Бичил зээлийн чиглэлээр бүлэг байгуулах сургалтыг 16 суманд зохион явуулснаас Хутаг-Өндөр, Баян-Агт, Булган, Дашинчилэн, Бүрэгхангай, Гурванбулаг, Хишиг-Өндөр сумдад идэвхитэй сайн зохион байгууллаа. Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөрыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үлгэр жишээ шилдэг гэр бүлүүдийн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “ТЭНГЭРЛЭГ ГЭР БҮЛ “ шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж 54 гэр бүлийг шалгаруулан оролцуулав.

/ Хэрэгжилт 90,0 хувь/

Ахмад дайчдын орон сууцны хангамжийг сайжруулахад зориулж тодорхой хэмжээний хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган шинээр барьсан орон сууцнаас тэдэнд ээлж дараатайгаар олгох ажлыг зохион байгуулж байна. Дайнд оролцсон 4 ахмад дайчдад орон сууц худалдан авахад нь 140 сая төгрөгийг олгосон байна.

/Хэрэгжилт

85,0 хувь/

Аймаг , сум орон нутагт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр , 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх нөхцлийг тусгах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх талаар сумдын удирдлагуудад чиглэл өгч ахмад дайчдыг орон сууцтай болгоход нь анхааран ажиллаж байна.

/Хэрэгжилт 85,0 хувь/

Аймгийн хэмжээнд 38 худаг шинээр гаргаж, 1 худаг засварлан, 46 булаг шандны эхийг хамгаалж, 350 мян.га орчим бэлчээрийг усжуулснаар бэлчээрийг зохистой хуваарилан ашиглах, сэлгэх нөхцөл бүрдэж, цөжилтөөс урьдчилан сэргийлэх, цөлжилтийг сааруулахад ач холбогдол өгөх чухал арга хэмжээ болсон.

/Хэрэгжилт 100.0 хувь/

2009 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 34 ажил тусгагдсанаас зураг төсөл нь бэлэн болоогүй Шадар сайдын багцаас эрх шилжиж ирсэн Булган сумын Соёлын төв, анхдагчуудын музей, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх сургалтын төвийн барилга байгууламж, тусгагдсан нь цаг хугацаа алдах, ашиглалтанд орох хугацаа хойшлох, төлөвлөсөн хөрөнгөө ондоо бүрэн ашиглах боломжгүй болоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжиж ирсэн Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын 100.0 сая төгрөгийн засварын ажлын зураг төсөв хийлгэх, тендер зарлах ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс одоо болтол засварын ажил эхлээгүй байна. **/Хэрэгжилт 90,0 хувь /**

Булган хотын ерөнхий төлөвлөгөөг Хот байгуулалт ТӨҮГ-аар хийлгэн төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын ажлыг хийж байна. Уг төлөвлөгөөнд нутаг дэвсгэрийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураг хамт боловсруулагдсан. 2010 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган хотын ерөнхий төлөвлөгөөнд хэсэгчилсэн төлөвлөлт хийлгэхээр хөрөнгийн асуудлыг шийдвэрлээд байна. **/ Хэрэгжилт -70,0 хувь /**

Барилга хот байгуулалтын албыг Монгол улсын Засгийн газрын тогтоолын дагуу бүтцийн өөрчлөлт хийж, ГХБХБГ -ыг шинээр байгуулж, үйл ажиллагаа нь жигдэрч байна. 2009 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулсан барилга байгууламжийн техникийн бичиг баримтын бүрдлийг архивлан нэгтгэж, аймгийн төв архивд хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.

/ Хэрэгжилт 100,0 хувь /

Малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас 8 тн овъёс, 6 тн хөх тарианы үр хувиарласаныг 11 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр олгож, 106 га-д тариалалт хийв. Мөн Эрчимжсэн МАА , газар тариаланг хослон хөгжүүлэх НҮБ-ийн төслөөр 2 аж ахуйн нэгж 10 гаруй га-талбайд тэжээлийн ургамал тариалсан. Малын тэжээл хөтөлбөрийг манай аймгийн Сэлэнгэ сумын ургацын түрүү хоршоо, Хангал сумын Сүмийн нуга хоршоодыг сонгон авч тэжээлийн ургамал тариаллаа. Тэжээлийн ургамалын нэр төрөл нэмэгдэж рапс, овъёс, арвай, ногоон тэжээлийн тариалалт нэмэгдлээ. Аймгийн "Малын тэжээл" дэд хөтөлбөрийг боловсруулан гаргалаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 2009 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвд тусгасан.

/Хэрэгжилт 100 хувь /

Аймгийн хэмжээнд улс, аймаг, орон нутгийн хамгаалалтад байдаг түүх, соёлын үйл хөдлөх дурсгалт зүйл 105 байгааг тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар ойролцоо нутагладаг иргэдэд хариуцуулж байна. Бугат сумын нутаг Овоотын өврийн буган чулуун хөшөө, мөн сумын нутаг дахь Бичигт гармын бичээс, Ямаа майлдагийн хадны сүг зураг зэрэг олдворууд шинээр олдсоныг бүртгэл мэдээллийн санд орууллаа. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын байдалд МХГ-тай хамтран үзлэг хийж дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргууллаа.

/ Хэрэгжилт 100,0 хувь /

Албан ажлын автомашин хэрэглэдэг албан тушаалтнуудаас хүсэлт гарган, шатахууны зардлыг мөнгөн хэлбэрээр авсан албан тушаалтан одоогоор байхгүй байна.

/Хэрэгжилт

100,0 хувь/

Харъяа агентлаг байгууллагуудаас авто машин гаргуулан , шатахууны зардал төлүүлэн , ажил гүйцэтгүүлээгүй болно .

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор Аймгийн ЗДТГазар , Засаг даргын дэргэдэх агентлагуудын албан хэрэгцээнд хэрэглэх дуудлагын авто машины тоо , жилд явах км-ийн хэмжээг батлуулан жил бүр мөрдөн ажилласнаар шатахууны зардлыг хэтрүүлэн хэрэглэдэг зөрчил буурсан .

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа цэгүүдэд аттестатчилал хийлээ. аттестатчилалд 172 цэг хамрагдаж 10 цэгийн эрхийг хасаж 20 цэгийн эрхийг түдгэлзүүлээд байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Үйлдвэр худалдааны сайдын 110 тоот тушаалын дагуу жил бүр архи согтууруулах ундаа худалдан борлуулж байгаа аж ахуй нэгжүүдийг аттестатчилж шаардалга хангаагүй болон зөрчил гаргасан цэгүүдийг хасах арга хэмжээ авч байна. Аймгийн хэмжээнд 162 цэг үйл ажиллагаа явуулж байна энэ оны 9 сард аттестатчлал хийлээ.Аймагт мөрдөгдөх нормативт хэмжээнд хүргэж хэрэгжилтийг хангаж нэмж цэг олгохгүй байх чиглэлийг холбогдох газруудад өгөөд байна.

/Хэрэгжилт 50,0 хувь/

Монголын тогооч нарын холбоотой хамтран албан байгууллагын дэргэдэх хоол үйлдвэрлэлийн газруудын тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор эмнэлгийн тогооч нарт “Эмчилгээ сувилгааны хоол”, сургууль цэцэрлэгийн тогооч нарт “Хүүхдийн хоол” сэдэвт сургалтуудыг зохион байгууллаа. Хүнсний баталгаат байдал, хоол үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд аймагтаа “Үдийн цай” сэдэвт Төвийн бүсийн тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж харилцан туршлага солилцуулах улсын уралдаан, сургалт семинарыг “Монголын тогооч нарын холбоо”, “Хоол үйлдвэрлэлийн хөгжлийн төв”-тэй хамтран зохион байгууллаа. Хүнсчдийн холбоотой хамтран "Зохистой хооллолт" сургалт, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулж орон нутгийн хэвлэл мэдээллээр цацлаа.

/Хэрэгжилт -

100,0 хувь/

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл шинээр нэмж олгоогүй байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Багийн Засаг дарга нарын үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Багийн хөгжлийг дэмжих " үндэсний хөтөлбөр батлагдсаны дагуу аймагт багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг болосвруулан баталж хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлээд байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээний төлөвлөгөөнд заагдсан ажлыг жил бүр сумдад даалгаж ажиллаж байгаа бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хөрөнгийн асуудлыг шийдэж сумдад хүргүүлдэг.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Хөтөлбөрийн хүрээнд сум бүр жишиг багаа тодорхойлсон бөгөөд хөтөлбөрийн талаар хагас бүтэн жилд хяналт шинжилгээ хийж газар дээр нь 2 удаа очиж шалгалт хийж хэвшээд байна. Жишиг багуудыг ээлж дараатайгаар тохижуулах төсөл хөтөлбөрт хамруулж тэдний хүч бололцоог ашиглах зэрэг арга хэмжээ авсны дүнд зарим нэг сумдын багийн төвийг шниэээр барьж сэргээн засварлаад байна.

/Хэрэгжилт 100,0

хувь/

Аймгийн нутаг дэвсгэрт хувиараа алт олборлолт байхгүй бөгөөд Дашинчилэн сумын Хараат багийн нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож байсан 160 иргэдийг шалгаж, хариуцлага тооцон ажиллав. Мөн Бүрэгхангай сумын 3-р багийн нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлож байсан 180 иргэдтэй уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааг зогсоон үлээгч 3, 30-аад хүрээ, лоом, зээтүү хураалаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Манай аймгийн Орхон сумын Мааньт багт байрлах Хорих 439 дүгээр анги 2007 оны 188 дугаар тогтоолоор Онцгой дэглэмтэй хорих анги болж байгуулагдсан бөгөөд Байгалийн шохойн орд газар дээр үйлдвэрлэл явуулж байна.

/Хэрэгжилт 80,0 хувь/

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд холбогдох байгууллагын дүгнэлт, шийдвэр гаргуулан гэрээ байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж эхэлдэг нийтлэг зөрчил гарсаар байна. Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрээс алт олборлогч Хос хас ХХК-ний хаягдал эфель угааж буй Сонгомол ХХК-д торгуулийн арга хэмжээ авч авсан. Тэшиг сумын нутаг дэвсгэрээс алт олборлогч Азаргын гол чонот ХХК нь энэ онд ус ашиглах зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан боловч 2008-2009 онд усны нөөцөд хохирол учруулсан тохиолдол гаргаагүй болно.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгж иргэдийг дэмжих зорилгоор 2009 онд аймгийн тариалан эрхлэгчдийг дэмжих сан байгуулж ашиглах, журмыг боловсруулан ажиллаж байна. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар атрын 3 аяныг хэрэгжүүлэх зорилгоор 10,0 сая төгрөг батлуулж үйл ажиллагаанд зарцууллаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

2009 онд “Атрын III аян” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн мөрдөн ажиллаж байна. 27249 га талбайд үр тариа, 875,5 га талбайд төмс, 300 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 30291 га талбайд уринш бэлтгэж өмнөх жилээс 4,0 мянган га-аар илүү, усалгаатай тариалангийн хэмжээг 1736 га-д хүргэж, инженерийн хийцтэй усалгааны систем ашиглалтанд орж 676 га-д усалгаатай үр тариа тариаллаа. энэ жил 30000 га-д уринш бэлтгэхээр төлөвлөж 30291 га талбайд уринш бэлтгэлээ.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Бүрэгхангай суманд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй Есөн эрдэнэ ундрага ХХК, Сонгомол хүлэг ХХК –иуд хаягдал эфель угаан алт олборлож байгаа бөгөөд орон нутгийн төсөвт газрын төлбөр, ус ашигласны төлбөрийн орлогыг оруулж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Манай аймагт одоогоор хувиараа алт олборлодог иргэд байхгүй бөгөөд аймгийн газрын алба, Цагдаагийн хэлтэс, Хууль зүйн хэлтэс, байгаль орчин аялал жуулчлалын газарт энэ журмыг хүргүүлж ажиллалаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

ХЗХ-ийн дэргэдэх Иргэний бүртгэлийн алба нь аймгийн Засаг даргын 2009 оны 206 тоот захирамжаар Улсын бүртгэлийн хэлтэс болон бүтэц зохион байгуулалт нь өөрчлөгдөн ажиллаж байна. Тус хэлтэс нь хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, иргэний бүртгэл гэсэн 3 төрлөөр бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Булган сумын хэмжээнд 2009 онд бүртгэл мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгон, цаашид бүх сумдыг бүртгэлийн нэгдсэн сүлжээнд хамруулах ажлыг төлөвлөн ажиллаж байна.

/ Хэрэгжилт 100.0 хувь / ХАСАХ

САНАЛТАЙ БАЙНА

Булган хотыг цэвэр усаар хангах цэвэр усны байгууламжийг 120,0 сая төгрөгийн өртөгтэйгээр барьж байгуулах ажил хийгдэж байна. Энэ төслийн хүрээнд 2 гүний худаг, 150 м3-ийн багтаамжтай 2 ус хадгалах резевар, 1,7 км хоолой тавих ажил хийгдээд байна.

Хутаг-Өндөр сумын сахар, ходоодны өвчинд хэрэглэдэг Их булгийн рашааныг орон нутгийн хамгаалалтанд авч, улсын рашааны тооллого, шинжилгээнд хамруулсан.

Баян-Агт сумын Хөтөл усны булаг, Өвдөгийн булгуудын эхийг хашиж хамгаалан тохижуулж, ус тосох цорго байрлуулсан нь орон нутгийн айл өрхүүдэд халдварт өвчин тархах нөхцлийг хааж, хүн амын эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авлаа.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Ой зохион байгуулалтыг хийлгэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, 2010 онд хийхээр боллоо.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Иргэний нийгмийн байгууллагын зөвлөлтэй байгуулсан 3 талт гэрээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга, аймгийн иргэний нийгмийн байгууллагын сүлжээтэй хамтран ажиллах төлөвлөгөө батлуулан төр төсвийн байгууллагын төсвийн гүйцэтгэл, бараа ажил үйлчилгээ худалдан авах журамд хяналт тавих боломж нөхцөлөөр ханган сар бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цацаж хэвшээд байгаа болно. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Тайлан мэдээг цаг хугацаанд нь явуулсан болно.
/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн хэмжээнд төв суурин газрын хог хаягдлын төвлөрсөн цэгүүд хүн амын суурьшил, үйлдвэржилтийн бүсээс алслагдсан байршилтай байдаг.
/Хэрэгжилт 100,0 хувь/

Монгол улсын дунд хугацааны буюу 2009-2011 оны төсвийн төслийг хөтөлбөрт суурилсан төлөвлөлтийн зарчимаар төсвийн төлөвлөлтийг боловсруулан ажиллаж байна
/Хэрэгжилт 100,0 хувь/

Засгийн газрын 139-р тогтоолоор сум бүрт агропарк байгуулахаар 11.5 сая төгрөгний хөрөнгө хувиарлан агропарк байгуулсан. Уг төслөөр 1960 м/кв. хүлэмж барьсан. 2009 онд хүлэмжинд тарьсан талбайгаас 7230 кг ногоо хураан авсан. Мөн 505 тн-ы багтаамжтай 12 зоорь барьж, 100 гаруй тн хүнсний ногоог зоорилоод байна. Агро паркын зориулалтай олгосон бага оврын трактороор 332 тн хадлан бэлтгэж 16.0 га талбайн хөрс боловсруулах ажил гүйцэтгэсэн. Сумдын агропаркуудад 24 удаагийн сургалт хийгдэж, нийт 605 хүн хамрагдаж зөвлөмж, тараах материалаар хангасан. “Агропарк”–д тариалсан талбайгаас 14.3 сая төгрөгний орлого олсон байна.
/Хэрэгжилт 100,0 хувь/

2008 онд тусгай зориулалтаар агнах ангийн орлогыг төсөвт төвлөрүүлж ажилласан бөгөөд 2009 онд тусгай зориулалтаар ан агнаагүй.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад 2004-2008 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө , хөтөлбөр төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн судалгааг сум байгууллага бүрээр гарган Төрийн өмчийн хороонд хүргүүллээ. Судалгаагаар нийт 28.2 тэр бум төгрөгийн их засвар болон хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна. Мөн данс бүртгэлд тусгагдаагүй орхигдсон хөрөнгийг тухайн байгууллагын бүртгэлд тусгуулан ажилласан талаархи мэдээллийг гарган ТӨХороонд хүргүүлэн ажиллав .

/ Хэрэгжилт 100,0

хувь /

2009 онд Улсын төсвийн санхүүжилт хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан нийт 14 орчим барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд орж хяналт тавин ажиллалаа.

/ Хэрэгжилт 100,0 хувь /

"Нийгмийн ажилтны арга зүй - 2009" сургалт зохион байгууллаа. Сургалтанд сумдын ХХҮ-ний мэргэжилтнүүд оролцож 2009-2012 онд нийгмийн салбарын үндсэн чиглэл, нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар тодорхой ойлголт чиглэлтэй болсон. "Халамжийн үйлчилгээний менежер программ" сэдэвт 7 хоногийн сургалт зохион байгуулагдаж сумдын ХХҮ-ний мэргэжилтнүүд бүрэн хамрагдаж нийгмийн халамжийн мэдээллийн сан бүрдүүлж ажил үйлчилгээндээ ашиглаж байна. Нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн хүрээнд ХХҮ-ний мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 3 шатны сургалт, "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх", "Халамжийн хууль"-ийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор 5 өдрийн сургалтыг ХХҮГ-тай хамтран зохион байгуулж сумдын ХХҮ-ний мэргэжилтнүүдийг 100 хувь хамруулан ажиллаж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

2009 онд аймгийн хэмжээнд "Оролцооны аргаар өрх, хүн амын амьжиргааны түвшин тогтоох үзлэг"-ийг зохион байгуулан, өрх хүн амын мэдээллийн санг байгуулж, "Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г боловсруулан ИТХ-ын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас дэмжлэг үзүүлж сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, сумдын удирдлага, нийгмийн ажилтнуудад "ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН ГЭР БҮЛИЙН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА, ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ", "ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ" сэдвээр Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганатад бүсчилсэн сургалт хийлээ. Нийгмийн "Халамжийн үйлчилгээний менежер" программыг нэвтрүүлсэнээр одоогийн байдлаар мэдээллийн нэгдсэн баазад 16637 иргэн болон хүүхдийн мэдээлэл нэгтгэгдээд байна. Ингэснээр иргэдийн мэдээлэл ил тод болж үйлчилгээ хөнгөн шуурхай болгоно. Иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж хамтарч ажиллах талаар санал солилцож суманд ажиллаж байгаа "Амьжиргааг дэмжих зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд тэдний төлөөллийг оролцуулж нийгмийн халамжийн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.

/Хэргжилт 100,0 хувь/

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд, сумдын удирдлага, нийгмийн ажилтнуудад "ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БОЛОН ГЭР БҮЛИЙН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА, ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ", "ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ" сэдвээр Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганатад бүсчилсэн сургалт хийлээ.

Иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж суманд ажиллаж байгаа "Амьжиргааг дэмжих зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд тэдний төлөөллийг оролцуулж нийгмийн халамжийн үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2009 оны үндсэн хөрөнгийн тооллого, хөрөнгийн дахин үнэлгээний ажил холбогдох заавар журмын дагуу хийгдэн тайлан балансад тусгагдахад бэлэн болоод байна.

/ Хэрэгжилт 100,0 хувь /

Итгэлийн зээлийг манай аймаг 2 тэр бум төгрөг авч 408 сая төгрөг төлөгдөөгүй байна. Энэ нь 2008 онд байгалийн гамшиг ган гачгийн улмаас эргэн төлж чадаагүй аж ахуй нэгж иргэд 2009 оны ургацаас төлөх боломжтой гэж тооцсон тул аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг шинэчилсэн гэрээ байгуулж, төлөх боломжгүй зарим аж ахуй нэгжийг шүүхэд шилжүүлсэн. **/Хэрэгжилт 80,0 хувь/**

Аймгийн хэмжээнд улс, аймаг, орон нутгийн хамгаалалтад байдаг түүх, соёлын үйл хөдлөх дурсгалт зүйл 105 байгааг тухайн орон нутгийн Засаг даргын захирамжаар ойролцоо нутагладаг иргэдэд хариуцуулан өглөө. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар Булган Мээж ХХК-ийн ТУЗ-ийг шинээр байгуулж, компанийн дүрэм, дотоод журам, ТУЗ-ийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулаад байна. " Хоёрдогч хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах төсөл"-ийн цэвэр усан хангамжийн нэгдсэн системийг барих ажил бүрэн дуусаагүй, улсын комисст хүлээлгэн өгөөгүй байгаа тул хувьчилах, өөрчлөн байгуулах асуудлыг ашиглалтанд өгсний дараа хийхээр төлөвлөж байна. **/Хэрэгжилт 30,0 хувь/**

Хүүхдийг халдвараас сэргийлэх талаар эрүүл мэндийн сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу явуулж хэвшүүлээд байна.Сургалтыг эрүүл мэндийн сайн дурын туслагч, эцэг, эхчүүд, өсвөр үеийнхэнд 5 удаа зохион байгуулан 500 гаруй хүнийг хамруулсан байна.Эрүүл мэндийн сурталчилгааны материалыг аймгийн Эрүүл мэндийн газрын сургалтын албанаас гарган, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд дээр тараан, сургалтыг зохион байгуулан явуулж байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Халдварт өвчнөөс сэргийлэх, гар угаах арга, томуугийн үеийн анхан шатны арга хэмжээний талаар зөвлөмжийг иргэдэд хүргүүлэн ажиллаж байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хүүхэд олноор цугладаг тоглоомын газруудад хяналт шалгалт хийж, хугацаатай үүрэг өгч ажилласан. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна." Дэлхийн-зөн" байгууллагаас эмзэг бүлгийн 40 өрхийн хүүхдэд нэмэгдэл тэжээл өгсөн.

/Хэрэгжилт 70,0 хувь/

Эрүүл мэндийн байгууллагууд халдварт өвчний тархалт, тандалтын судалгааг тогтмол хийж хэвшүүлсэн.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Ургамлын хорио цээр тогтоох өвчин гараагүй байна

/Хэрэгжилт 100,0 хувь/

Архидалт мансуурлын эсрэг ассоциацитай хамтран Архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх сэтгэл заслын кабинет байгуулан аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологиын тасгийн дэргэд ажиллуулсан. Энэ чиглэлээр эмчлэгдсэн нэг иргэн Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төвийн Булган аймаг дахь салбарыг байгуулан аймгийн ГХУСА33-тэй хамтран урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулж байна. Сэтгэц наркологиын тасгийн орны тоо хасагдаж, төлбөр өссөнтэй холбоотой энэ чиглэлийн эмчилгээ үйлчилгээг нэгдсэн журмаар зохион байгуулах боломжгүй болсон. 2010 оноос эхлэн асуудлыг дахин судалж, шийдвэрлэхээр ажиллаж байна

/Хэрэгжилт 70,0 хувь/

Дунд хугацааны төсөв, төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын хязгаарыг боловсруулж, хэтийн төлөвлөгөөнд тусгаж ажилласан бөгөөд энэ тухай тайлан мэдээг эрх бүхий дээд шатны байгууллагад хүргүүлээд байна.

/Хэрэгжилт 70,0 хувь/

Тогтоолоор батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд төрийн албны салбар зөвлөлтэй хамтарч ажиллаж байна.

/Хэрэгжилт 70,0 хувь/

2009 онд МУ-ыг Хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгагдаагүй

/Хэрэгжилт

100,0 хувь/

"Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил"-д ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж аймгийн төвд ахуйн үйлчилгээний төв, сумдад цэг бий болгох зорилт дэвшүүлж эхний ээлжинд Орхон сумын ахуйн үйлчилгээний төвлөрсөн цэгийн барилгын засвар үйлчилгээг "Тогтвортой амьжиргаа II" төслөөр санхүүжүүлж, ахуйн үйлчилгээний үйл ажиллагааг өргөжүүлэх 13 бизнес төсөлд 80,0 гаруй сая төгрөгний дэмжлэг үзүүллээ. Аймгийнхаа ахуй үйлчилгээний салбарт ажиллагсадыг ХХААХҮЯ, Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбоо, Орхон аймгийн Засаг даргын тамгын газраас хамтран зохион байгуулсан "Ахуйн үйлчилгээний жишиг төв" төвийн бүсийн үзүүлэх сургалт, үзэсгэлэнд оролцуулж туршлага судлуллаа.

/Хэрэгжилт - 95.0 хувь/

Аймагт гадаад хэлний сургалтыг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулахаар бэлэн болгоод байна. Булган сумын 1-р бүрэн дунд сургууль, "Эрдмийн өргөө" цогцолбор сургууль, Спортын дунд сургуулиудад тус бүр 21 компьютер бүхий англи хэлний лингафон кабинетуудыг байгуулж, Гурванбулаг суманд англи хэлний кабинет тохижуулаад байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

аймгийн хэмжэнд 2009 онд гоц халдварт өвчин гараагүй байна. Харин малаас хүнд халддаг галзуу өвчин Баяннуур, Орхон Гурванбулаг, Бүрэгхангай суманд оношлогдож Баяннуур суманд 1 сарын хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоож ажиллаа. галзуу өвчний вакциныг тус сумдын малд урьдчилан сэргийлж тариалга хийсэн. шувууны томуугийн тандалт судалгааг Сайхан, Баян-Агт, Тэшиг, Баяннуур сумдын 6 нууранд хийж байна.

/Хэрэгжилт 70,0 хувь/

Боловсрол соёлын газартай хамтран 14 сум, 1 тосгоны ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудад зөвлөн тусалж, 866 багшийг хамруулан 509 багшаас мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг төстээр авч, 64 зөвлөмжийг бичиж хүргүүллээ. 2009 онд давхардсан тоогоор 1400 багш мэдлэг боловсролоо дээшлүүлсний 854 нь орон нутагт, 265 нь бүсийн, 122 багш төвлөрсөн, 160 гаруй багш ажлын байранд тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагджээ. Мөн Малайз, Сингапур, БНСУ-д БСГ-ын мэргэжилтэн, ЕБС-ийн мэдээлэл зүйн багш тус бүр 1 хүний мэргэшлийг дээшлүүлсэн байна. МУБИС-тай хамтран Гурванбулаг суманд монгол хэл, гадаад хэлний багш нарын модуль сургалтыг зохион байгуулан, шилдэг илтгэлийн уралдаан явуулж, анх удаа МУБИС-ийн магистантурын элсэлтийн шалгалтыг зохиож 7 багшийг элсүүллээ. Мөн Боловсролын Үнэлгээний Төвтэй хамтран “Үндэсний шинжээч багшийн сургалт”-ыг аймагтаа зохион байгуулж, 21 багшийг үндэсний шинжээч болголоо. Түүнчлэн бага ангийн 11 багшид англи хэл заах сургалтыг орон нутагт анх удаа зохион байгуулж, сургалт эрхлэх зөвшөөрөл олгоод байна. Шинээр багшлах эрхийн үнэмлэх авахаар 75 багш материалаа ирүүлснийг хянан 65 багшийн материалыг БСШУЯ-нд явуулснаас 60 хүн багшлах эрхийн үнэмлэх авлаа.

/Хэрэгжилт 100,0 хувь /

Аймгийн Засаг даргын 20 тоот захирамжаар "Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил" болгон зарлаж жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилж, ажлын удирдамж, төлөвлөгөө гарган, болзолт уралдаан зарлаж хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаа. Жилийн ажлын хэрэгжилтийн үр дүнг аймгийн ИТХ-ын V дугаар хуралдаанаар хэлэлцүүлж орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилаа. Орон нутгийн түүхий эд, боломжид тулгуурласан жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгаж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хүүгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлсэнээр төлөвлөгөөний биелэлт 90,0 хувийн биелэлттэй байна.

/Хэрэгжилт - 100.0 хувь/

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт болон байгалийн нөөц газруудыг хамгаалах аймгийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд түүх дурсгалын газрыг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтанд авч бүрэн бүтэн байдалд хохирол учирахуйц үйл ажиллагаа явуулах, хамгаалалтын бүсэд барилга байгууламж барихыг хориглох арга хэмжээ авахыг сумдын засаг дарга нарт үүрэг болгож ажиллаж байна. Рашаант сумын "Хөгнө тарнийн" дээд доод туурийн тэнд тухайн хийдийн хамба лам нар Ой моджуулах төслийг хэрэгжүүлж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь /

Дайнд оролцсон ахмад дайчдын судалгааг шинэчлэн гаргаж НХХЯ-д хүргүүлэн ажиллаж 4 ахмад дайчдад орон сууц худалдан авахад нь зориулж 140 сая төгрөгийг олгоод байна. Ахмад дайчныг орон сууцаар хангах, мөнгөн тусламж олгох арга хэмжээг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байна.
/Хэрэгжилт 90,0 хувь/

Төлөвлөгөнд тусгагдсан ажлыг шуурхай хэрэгжүүлж хэрэгжилтийн явц байдалд 6, 12 сарын байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт мэдээлж хэвшээд байна. 2009 оны 12 сарын байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 91,0 хувийн биелэлттэй байна.
/Хэрэгжилт 90,0 хувь/

2009 оны үндсэн чиглэлд 2 салбарын 3 зорилт 7 арга хэмжээ төлөвлөж хэрэгжилт 94,3 хувьтай байна.
/Хэрэгжилт 94,0 хувь/

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын 92 тоот захирамжийг гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийтийг хамарсан 21 уралдаан тэмцээн зохион байгуулан, давхардсан тоогоор 3000 хүнийг хамруулсан байна. Булган сумын төвд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан мөсөн гулгуурын талбай байгуулан ажиллаж байна. Биеийн тамир спортын чиглэлээр 6 спортын холбоод үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд биеийн тамир спортын талаар 2009-2012 онд баримтлан ажиллах бодлогыг боловсруулан гаргасан.
/Хэрэгжилт 90,0 хувь/

Шаардагдах санхүүжилтийг аймгийн биеийн тамир спортын газрын төсөв тусган хэрэгжүүлж байна. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Үндэсний хөтөлбөрийг аймгийн соёлын байгууллагууд, ард иргэдэд сурталчиллаа. **/ Хэрэгжилт 30,0 хувь /**

Малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас 8 тн овьёс, 6 тн хөх тарианы үр хувиарласаныг 11 аж ахуйн нэгж, 3 иргэнд гэрээгээр олгож, 106 га-д тариалал хийлээ. Мөн Эрчимжсэн МАА , газар тариаланг хослон хөгжүүлэх НҮБ-ийн төслөөр 2 аж ахуйн нэгж 10 гаруй га-талбайд тэжээлийн ургамал тариалсан Бугат суманд 1, Булган суманд 2, Могод суманд 1, Хутаг-Өндөр суманд 1, Хишиг-Өндөр суманд 1, Сайхан суманд 1 сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулж аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас нийт 125 сая төгрөгийн зээл олголоо. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр бичигдсэн төслүүдийг сонгон шалгаруулж Францын хүнсний тусламжийн сангаас 11 төсөлд 76,5 сая төгрөгийн зээл олгогдсон. мөн мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр бичигдсэн төсөлд аймгийн ЖДҮДС-аас 99 сая төгрөгийн зээл олгож үйл ажиллагааг нь дэмжлээ.

Мянганы хөгжлийн сорилтын сангаас хэрэгжүүлж байгаа “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн шугамаар Хангал, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Бугат сумдад 56 эрчимжсэн аж ахуй байгуулахаар малчин өрх сонгогдоод байна **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Сумдын Засг даргын тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоон батлагдсан хэмжээний дагуу бүтэц орон тоогоор ажиллууллаа. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Аж ахуйн нэгж байгууллагаас Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг ХХҮХэлтсийн тусгай дансанд тушаалгаж байна. Манай аймагт 25 болон түүнээс дээш ажилтан албан хаагчтай аж ахуйн нэгж, байгууллага 75 байдгаас одоогийн байдлаар бүх сумдын Хүн эмнэлэг, Сургууль, Цэцэрлэг, Цэргийн анги, Засаг даргын Тамгын газруудаас хөгжлийн брхшээлтэй ажиллагсдын судалгааг авч дүгнэлт хийж байна. .

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангаж ажлын байртай болгох хөтөлбөрт хамруулах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Хэн болох нь тогтоогдоогүй хариуцах эзэнгүй цогцосыг оршуулах зардлыг 2009 оны төсөвт тусгагдаагүй байна. 2009 онд хариуцах эзэн тогтоогдоогүй ийм цогцос 1-ийг оршуулах ажлыг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан байна. 2010 оны төсөвт эзэнгүй цогцос оршуулах төсөв хөрөнгө тусгагдаагүй байна. Энэ талын үндэслэл бүхий тооцоо судалгаа харьцуулсан дүнгийн тухай саналыг боловсруулан ХЗХ-т ирүүлэхийг ШША-д мэдэгдэн ажиллаад байна. **/Хэрэгжилт 80.0 хувь/**

"Хүнсний баталгаат байдал"- дэд хөтөлбөр боловсруулж стратегийн хүнсний хэрэглээний судалгааг гаргаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулахад бэлэн болгоод байна. Энэ онд аймгийн хэмжээнд хүнсний үйлдвэрлэл болон хангамжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, төсөл хөтөлбөрүүдээс нийт 3,0 тэр бум гаруй төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж хүнсний боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оноос 45,3 хувиар өслөө. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас хүнсний үйлдвэрлэл, хангамжыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 31төсөлд 420,5 сая төгрөг, Францын "Өрхийн хүнсний хангамжын бие даасан байдлыг сайжруулах" төслөөс 11 төсөл 76.7 сая төгрөгний санхүүжилт авч төслөө хэрэгжүүлж байна. 2009 онд Хутаг- Өндөр, Бүрэгхангай, Сэлэнгэ сумдад гурилийн үйлдвэрүүд шинээр байгуулагдаж, Орхон, Хутаг- Өндөр, Сэлэнгэ, Тэшиг сумдын гурилын үйлдвэрүүд тоног төхөөрөмжийг шинэчилж хүчин чадлыг нь нэмэгдүүлсэнээр аймгийн хүн амын хэрэгцээг бүрэн хангахаас гадна бүсийн аймгуудад гурил нийлүүлж эхлээд байна. Агропарк төслөөс аймгийн хэмжээнд 1920 кв.м талбай бүхий хүлэмж, 505 тн багтаамжтай зоорь баригдлаа. ХЯБХХН- ээс сумдад өрхийн төмс хүнсний ногооны тариалалтыг дэмжиж 8500.0 сая төгрөгний төмс хүнсний ногооны үр, 1700.0 мян.төг 3 хүлэмж олгосон. "Атар -3 аян"- аар хаврын тариалалтанд 4.2 мянган тн түлш 2500 тн үрийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож тариалан дэмжих сангаас 2 төсөлд 9.5 сая төгрөгний зээлээр дэмжлэг үзүүллээ. Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хоол үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг дэмжиж аймагтаа Төвийн бүсийн сургууль цэцэрлэгийн тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх "Үдийн цай" сэдэвт ажил мэргэжлийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

/Хэрэгжилт - 90,0 хувь/

2009 оны 12-р сарын 20-ны байдлаар цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хааж буй иргэдийн төлбөрийг 100 хувь барагдууллаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаахаар өргөдөл гаргасан 35 иргэний материалыг сумдын ЗДТГ,цэрэг татлагын товчооны саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр оруулан БХЯ-нд хүргүүлэв. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжилтийг сум, байгууллагад хүргүүлэн зохион байгуулж биелэлтийг тооцож байна. Төлөвлөгөөний биелэлт 75 хувьтай байна. 12 дугаар сарын 10-ны өдрийг тохиолдуулан Хүний эрх мэдээлэл сурталчилгааны нэгдсэн өдөрлөг зохион байгуулж, хууль хяналтын байгууллагууд хамтран хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаагаа сурталчиллаа. **/Хэрэгжилт 70,0 хувь/**

Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг тогтоосон цалингийн хэмжээг бууруулахгүйгээр олгож байхыг төсвийн ерөнхий менежер нарт зөвлөж ажиллаа. **/Хэрэгжилт 70,0 хувь/**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэж байгаа тендер шалгаруулалтын үед зарыг Монголын өдөр тутмын сонин хэвлэл болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mn хаягаар бүрэн тавьж нийтлэн үр дүнг мэдээлэн ажиллаж хэвшсэн **/Хэрэгжилт 100,0 хувь/**

МУ-ын ЗГ-ын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын самбарт мэдээллийг байнга тавин ажиллаж байна. **/Хэрэгжилт 80,0 хувь/**

Худалдан авах ажиллагааны чиглэлээр АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2009 онд байгууллагын төсөв захирагч болон менежерүүдэд 1 удаагийн сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд сургагч багшийн эрх авсан мэргэжилтэн сургалт зохион байгуулах ёстой бөгөөд манай аймгийн хувьд сургагч багш одоогоор байхгүй. **/Хэрэгжилт 50,0 хувь/**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны босго үнийг баримтлан харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэж хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаж байна. / Хэрэгжилт 100,0 хувь/

Хуульд заасан захиалагчийн эрх үүргийг биелүүлэн ажиллаж байна. Мөн хуулийн 49,2-т заасан худалдан авах ажиллагааны баримтыг архивын нэгж болгон хяналт шалгалтын байгууллагуудаар шалгуулсны дараа архивт шилжүүлэн өгч ажиллаж байна. /Хэрэгжилт 80,0 хувь/

УИХ-аас улс, орон нутгийн төсөвт тодотгол хийж бараа үйлчилгээний бусад зардлыг 30 хүртэл хувиар бууруулж баталсан болно. Үүнтэй холбогдуулж байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан төсөвтөө багтаан, зардал хооронд шилжүүлэн гүйлгэж зарцуулснаар орон нутгийн төсвийн байгууллагууд өргүй гарлаа. Харин орон нутгийн өмчийн дулаан хангамжийн Булган-Мээж ХХК нь халаалт дулаан, цэвэр бохир усны үнийг нэмэгдүүлж 2009 оны 10 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газар, Цагдаагийн хэлтэс, Сувилалын ясли, Халамж үйлчилгээний хэлтэс зэрэг байгууллагууд халаалт, цэвэр бохир усны өртэй гарч, бусад байгууллагууд өргүй гарлаа. /Хэрэгжилт 80,0 хувь/

Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвнийг бууруулах талаар Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аймгийн зөвлөлийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 100 тоот тогтоолоор байгуулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвнийг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авч хяналт тавин ажиллаж байна. Аттестатчилалд амжилттай сайн дүн үзүүлсэн байгууллага, хамт олны туршлага, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх шинэ санаачлага, ажлын зөв эхлэлийг нийтийн хүртээл болгох зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлыг зохион байгуулж байна. / Хэрэгжилт 85,0 хувь/

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн түншлэлийн талууд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулан Ажил олгогч эздийн холбоо, ҮЭ-ийн холбоо зэрэг ТББ- тай хамтарн ажиллаж, хамтын гэрээ, нийгмийн түншлэлийн гурван талт гарээнд тусган хэргжилтэнд хяналт тавин ажиллаж байна. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

Аймгийн төвийн байгууллага орон сууцны халаалтыг нэгдсэн системд шат дараатайгаар оруулах ажлыг төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж нам даралтын зуухны тоог цөөрүүлэх, тэдгээрт ажиллагсдын хөдөлмөрийн нөөцийг сайжруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Зураг төсөв нь хянагдаагүй хориотой бүс зөвшөөрөлгүй газарт барилга байгууламж шинээр барих явдлыг таслан зогсоох, нэг хүнд ногдох ажлын байрны талбайн хэмжээ барилга байгууламжийн чанар стандартын хэрэгжилтэнд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт тавин хамтран ажиллаж байна. **/Хэрэгжилт 85,0 хувь/**

Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг хангах чиглэлээр сумдад зааварчилгаа өгч ажиллаж байгаа бөгөөд э.нэ талаар аймгаас нэгдсэн комисс батлагдаж газар дээр нь очиж төр төсвийн бүх байгууллагууд дээр хэрхэн хэрэгжиж байгаа талаар шалгалт хийж ажиллаа. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Газар хөдлөлт бүртгэх Булган станц "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулаад байна. 2010 онд аймгийн хөтөлбөр боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. **/Хэрэгжилт 50,0 хувь/**

Төр төсвийн байгууллагаас тэтгэвэрт гарч байгаа албан хаагч нарын буцалтгүй тусламжийг журмын адгуу олгож байгаа бөгөөд энэ журмыг баримтлан ажиллахыг төр төсвийн байгууллагуудад чиглэл өгч ажиллаа. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Санхүүгийн хүндрэлтэй байгаа энэ үед албан хаагч нарыг төрийн албанаас чөлөөлөгдөх дараалал тогтоон ажиллаж байгаа бөгөөд төсөвт ямарваа хүндрэл үүсгэхгүй байх чиглэл баримтлан ажиллаж байна. Энэ чиглэлээр сумдын удирдлагуудад үүрэг чиглэл өгч ажиллав.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулж 2010 онд хийх ажлын төлвөлгөө гаргалаа. Санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүр орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламж төсөл хөтөлбөрт хамруулахаар тусгалаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Орон нутгийн нөөц боломж, эрэлт хэрэгцээнд түшиглэн хөгжүүлэх үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэцүүлэн батлуулж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлттэй зээл болон орон нутгийн зүгээс үзүүлж болох дэмжлэг туслалцаа боломжоор хангаж ажилласаны үр дүнд аймгийн төлөвлөгөөний хэрэгжилт 90,0 гаруй хувийн биелэлттэй байна.

/Хэрэгжилт -90,0

хувь/

Булган аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барилга угсралт засвар шинэчлэлт хийгдэхээр төлөвлөгдсөн барилга байгууламжийн зураг төслийн ажилд хянан магадлагаа хийж баталгаажуулан ажиллаж зураг төслийн байгууллагатай хамтран ажиллалаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2009-2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 8 заалт, 51 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тэргүүн ээлжинд эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, малыг эргэлтэнд оруулах, малчдын хамтын хөдөлмөрийг дэмжих хоршоо байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх талаар тусгаж өглөө.

/Хэрэгжилт 80,0 хувь/

2010 онд зохион байгуулагдах их наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах , авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Засаг даргын захирамжийг гарган, бүх сумдын ЗДТГ болон төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Батлагдсан төсвийн зарлагын хязгаарт багтаан 2010 оны төсвөө боловсруулан аймгийн ИТХ-аар батлууллаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Баяннуур суманд хадлангийн 7 салаа гарч байгалийн хадлан бэлж урд бүсийн сумд болон зэргэлдээ аймгуудад худалдан борлууллаа. аймгийн Засаг дарга ХХААХҮ-ийн сайдтай байгуулсан гэрээнд 80,0 мянган тн хадлан бэлтгэхээр гэрээ байгуулж 83,7 мянган тн хадлан бэлтгэлээ. мал өвөлжилт, хадлан бэлтгэх ажлыг эрчимжүүлэх аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгавар гаргаж ажиллаа. Аймгийн хэмжээнд 16 сум 1 тосгон, 74 багт 7800 орчим малчин өрхөд 2,6 сая гаруй мал өвөлжихөөр зохион байгуулагдаж, гаднаас өөр аймгийн 370 өрхийн 311365 мал отроор орж ирээд байна. Аймгийн хэмжээнд мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг 85 хувь хангасан дүнтэй гарлаа.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Мал аж ахуйн болон төв суурингийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах аймгийн нэгдсэн төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажлыг эртнээс ханган, өвлийн ид ачааллын үед хүндрэл багатай даван туулах нөхцлийг бүрдүүлэх талаар үүрэг чиглэл өгч, сумдын ажлын явцыг 2 удаа шалгаж, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

/Хэрэгжилт 100,0 хувь /

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Булган салбар нь өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Хутаг-Өндөр сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугмын тулгууруудын хазайсныг тэгшилж, манаас бэхэлгээ хийлээ. Хутаг-Өндөр, Дашинчилэн сумын 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг засварлаж дууслаа. Булган хотын Залуус хотхон, 14,15 дугаар байрны цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 1 дэд станц шинээр суурилуулж ашиглалтанд орууллаа. Булган хотын дулаан хангамжийг сайжруулах зорилгоор Булган –Мээж ХХК халаалтын 3 зууханд шинээр 5 тогоо суурилуулж, халахгүй байсан 4 байрны халаалтын системийг шинэчлэн засварлаж, 150,0 гаруй сая төгрөг зарцууллаа. Аймгийн хэмжээнд 10 төвлөрсөн халаалтын зуух, 65 объектийн зуухны бэлтгэлийг хангуулах ажил хийгдэж, нийт шаардлагатай нүүрсний 35.0 хувь буюу 5507 тн, модны 83,7 хувь буюу 8064 м³ –ыг татан авсан байна. Сум, аж ахуйн нэгж байгууллагуудийн өвөлжилтийн бэлтгэлийг шалгаж үзэхэд ихэнхи сумд хэрэгцээт модны 80-100 хувийг татан авч, 10039,1 тн н байгуулж, сургалт эрхлэх зөвшөөрөл олгоод байна. Шинээр багшлах эрхийн үнэмлэх авахаар 75 багш материалаа ирүүлснийг хянан 65 багшийн материалыг БСШУЯ-нд яву

Аймгийн шуудангийн үйлчилгээний газар, Тээвэр, авто замын газар нийтийн тээврийн хэрэгсэл тэдгээрийн гараашийн засвар дулаалгыг хугацаанд нь хийлээ. Одоогийн байдлаар шатахуун, тослох материалын хангамж хүрэлцээ зохих түвшинд байна. **/Хэрэгжилт 100,0 хувь /**

Булган аймгийн хувьд байгал цаг уурын байдал харьцангуй тааламжтай байсан малчид тодоохой хэмжээний өвс бэлтгэж авсан. аймгийн мал аж ахуй төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаа. Ихэнх сум бэлчээр хамгаалан талхлагдалыг багасгаж тодорхой хугацаанд /6-р сарын 25–наас 8-р сарын 25 хүртэл/ бэлчээрийг малын хөлөөс чөлөөлж, алсын оторт гаргасаны дүнд аймгийн нийт мал сүрэг дундаас дээш тарга хүч авсан. бэлчээр ашиглалт сайжирсан. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Аймгийн мал аж ахуй төв суурингийн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд цаг хүндэрсэн үед иргэд байгууллагын хүч анхаарлыг хандуулах, залуучуудын холбоотой хамтран энэ ажилд залуучуудыг татан оролцуулах тэдний хүчийг ашиглах талаар заалт орж залуучуудын холбоотой гэрээ байгуулсан. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Эрүүл мэндийн яамнаас баталсан " Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд сурталчлан ажиллаж байна.Стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яамтай хамтран " Зөв хоололт-Эрүүл хөдөлгөөн" бүсийн 6 аймгийн сургалт семинарыг зохион байгуулан явуулж, 60 гаруй хүнийг хамруулсан.Аймгийн хэмжээнд " Хөдөлгөөн-эрүүл мэнд"-ийг дэмжих чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж, төрийн байгууллагууд " Ажлын байранд хийх 10 дасгал"-ыг хийж хэвшүүлээд байна.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгуулагатай хамтран " Эмч танд зөвлөж байна" буланг ажиллуулан зөв хоололт, эрүүл хөдөлгөөний талаар эрүүл мэндийн сургалтуудыг явуулж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн Засаг дарга, Өвөрхангай, Төв, Дундговь аймгийн дарга нартай мал өвөлжүүлэх талаар гэрээ байгуулсан. Гэрээний дагуу малчид орж ирсэн, малчдад цаг агаарын аюулт үзэгдэл болон нийгмийн бусад арга хэмжээг хүргэж байна. Малчидтай уулзаж малыг МЭ-ийн арга хэмжээнд хамрагдсан эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Баяннуур суманд хадлангийн 7 салаа гарч байгалийн хадлан бэлтгэж урд бүсийн сумд болон зэргэлдээ аймгуудад худалдан борлууллаа. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэхэд хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэхээр "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-гийн хөрөнгийн хэмжээг орон нутгийн төсвөөс жил бүр 30,0 сая төгрөгөөс багагүй хэмжээний хөрөнгөөр нэмж санхүүжүүлэх шийдвэр гарган хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 2005-2009 онд орон нутгийн төсвөөс нийт 130,0 сая төгрөг төвлөрүүлж үйлдвэрлэл эрхлэгчдэд олгоод байна. Европын тусламж монголд төслийн ЖДҮ эрхлэлтийг дэмжсэн "Эргэлтийн сан" хөтөлбөрт хамруулхаар холбогдох судалгаа санал хүсэлтээ хүргүүлээд байна.

/Хэрэгжилт -100,0 хувь/

Энэ онд үйлдвэржүүлэлтийн бодлогыг тууштай дэмжиж хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласаны үр дүнд аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оноос 46,3 хувиар өсч, эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх ач холбогдол бүхий томоохон үйлдвэрүүд Хутаг- Өндөр, Хялганат, Хишиг-Өндөр, Булган, Сайхан, Могод зэрэг сумдад эхлэл нь тавигдлаа. Үйлдвэржүүлэлтийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн ИТХ-ийн V хуралдаанаар хэлэлцүүлж 2010 оны зорилтоо тодорхойллоо.

/Хэрэгжилт -100,0 хувь/

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон аймгийн хэмжээнд үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн тусгай бүлгийн болон аймгийн Онцгой комиссын ажиллагааг гамшгийн үеийн үйл ажиллагаанд шилжүүлэн бүх мэдээллийг өдөр бүр нэгтгэн авах арга хэмжээгээ шийдэж байв. Үүнтэй зэрэгцүүлэн хот хоорондын тээврийн ажиллагааг байнгын халдваргүйтгэл, хяналтын дор явуулан үүрэг бүхий байгууллагууд орой бүр орон нутгийн телевизээр сурталчилгаа хийж , мэдээллийг нэгтгэн танилцуулж байсан

/Хэрэгжилт 100,0 хувь/

Авч хэрэгжүүлж байсан арга хэмжээгээ үргэлжлүүлэн тухайн үед ажиллаж байсан байгууллага АА-н нэгжүүдийн ажиллагааг амны хаалттай явуулах, нойтон цэвэрлэгээг байнга хийж байх, МСҮТ-ын дотуур байрыг сийрэгжүүлэх, засварын ажлыг түргэтгэж, хүүхдүүдийг оруулах, ирцийн мэдээг тогтмол авч байгууллагууд ажиллагсадаа илчлэг бүхий хоолоор хангах, айл өрхөөр сурталчилгаа хийх зэргээр ажиллав.

/Хэрэгжилт 90,0 хувь/

Урамж

Иргэдийн дотоодын шилжилт хөдөлгөөнийг иргэний бүртгэл бүртгүүлж байх чиглэлээр сумдад чиглэл өгч, сум хоорондын шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж байна. Энэ онд сум, баг хоорондын шилжилт хөдөлгөөн өнгөрсөн онтой харьцуулахад 5-аар өссөн байна. **/Хэрэгжилт 90 хувь/**

2008 онд канон, принтер, джитал аппарат зэрэг техник хэрэгсэл авсан. Мөн 2009 оны төсөвт төрийн архивыг тохижуулах, техник хэрэгслээр хангах ажлын хүрээнд 7.385.100 төгрөгийг батлуулаад байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

ны тэмдэглэл

Архидан согтуурахтай тэмцэх ажлыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн тоог цөөрүүлэх, эдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, нөгөө талаас иргэдийн дунд зөв, соёлтой хэрэглээ, зан үйлийг сурталчлах, зөв амьдралын хэв маягт суралцуулах гэсэн бодлого баримталж байна. Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг эрхзүйн болон архины хор хөнөөл, Архинд донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх арга замын талаархи сургалтуудыг Хялганат, Булган, Сайхан, Хутаг-Өндөр зэрэг сумдад хийж, 300 гаруй хүмүүсийг хамруулав. энэ төрлийн сурталчилгааны ажилд Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төвтэй хамтран ажиллаж байна.

/Хэрэгжилт 80,0 хувь/

Архидан согтуурч байгаа хүмүүсийн талаархи судалгаа мэдээллийг Цагдаагийн хэлтэс дээр нэгтгэн, аймгийн ГХУСАЗЗ-д танилцуулж байна. Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж байгаа бөгөөд энэ ажлын төгсгөлд орон нутагт баримтлах бодлого, шийдвэрт өөрчлөлт оруулах, Архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх, эдгэрүүлэх чиглэлээр ажил зохион байгуулахаар төлөвлөж байна. Архинд донтох өвчний шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, архины хор хөнөөлийн талаархи сургалт лекцэнд 200 гаруй ахлах ангийн сурагчдыг хамрууллаа.

/Хэрэгжилт 80,0 хувь/

Шуудангийн Үйлчилгээний газар шууданг батлагдсан хуваарийн дагуу хүргэх ажлыг зохион байгуулж, 606 зорчигч тээвэрлэж, 29,6 сая төгрөгийн хэвлэл захиалга явууллаа. Хэрэглэгчдэд шуудангаар илгээсэн болон хүлээн авах илгээмжийн байршлыг гар утаснаасаа мессежээр мэдэх, хэвлэл захиалгаа интернетээр захиалах 2 төрлийн электрон шуудангийн үйлчилгээг шинээр нээгээд байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Орон нутгийн төсвийн орлогыг бүрдэх бүх талын арга хэмжээ авч ажиллаж байгаа ч аймгийн нутаг дэвсгэр дээр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлбөрийн орлого тасарч байна. Аймгийн татварын хэлтэс Сангийн яам болон Ашигт малтмалын хэрэг эрхлэх газартай тулгалт хийж ажиллаж байна, Цалин тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож хэвшсэн. **/Хэрэгжилт 90,0 хувь/**

2009 онд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтэц хөгжүүлэх салбаруудын ажил төлөвлөгдсөн хэмжээнд хийгдсэн. Тухайлбал Булган-Уньтын хатуу хучилттай замын ажлаас 28 км замыг ашиглалтанд хүлээн авч, аймгийн хэмжээнд ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр төгрөгийн зээлийг олгож, байнгийн ажлын байр.....-ыг бий болгож, газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос үсрэнгүй өссөн амжилттай байлаа. Энэ хэмжээгээрээ нэг хүнд ногдох ДНБ болж өслөө. аймгийн хэмжээнд гаднаас 1206 хүн шилжиж ирсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин өссөн байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Химийн бодисын улсын үзлэг, тоологын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, ажилласан бөгөөд ирэх оноос үзлэг тооллогыг шинэчлэн хийхээр төлөвлөж байна. **/Хэрэгжилт 100.0 хувь/**

Ойн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн “Дэд хөтөлбөр”-ийг I, II шаттайгаар ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна. Хяганат тосгонд сум дундын ойн ангийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулаад байна. Ой хээрийн түймрээс хамгаалах төлөвлөгөө батлуулж, жил бүрийн 4-6 дугаар сард 120-140 морин эргүүл ажиллуулдаг болсон. Мөн түймрээс урьдчилан сэргийлэх ажлаар сумдыг байр эзлүүлэн шагнадаг, хариуцлага тооцдог тогтолцоо бий болсон. Аймгийн ИТХ-аар модны жишиг үнийг тогтоолгон айл өрх албан газруудыг тарьц, суулгацаар хангаж, нийт 20658 ширхэг модыг шинээр тарьсны дээр 2714.65 м2 газрыг зүлэгжүүлж 2 сая, 560,0 мянган төгрөг зарцуулан арчлан хамгаалж байна. Энэ онд 969.4 га талбайг ойжуулж нөхөн сэргээгээд байна. 2010 оны ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлын бэлтгэлд аж ахуй нэгж байгууллагууд нь нийт 945000 ширхэг тарьц, 35000 ширхэг суулгац, 25 кг үрийг бэлтгэсэн. "Ашиглагч нь хамгаалагч байя" III зөвөлгөөнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулан зохион байгуулж мод бэлтгэлийн ажлыг мод бэлтгэгч эрх бүхий 3 аж ахуйн нэгжээр хийлгэж, бусад аж ахуйн нэгжүүдийг эдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зөвхөн зүсмэл үйлдвэрлэхээр зохион байгуулалт хийсэн болно. Мод бэлтгэгч аж ахуй нэгж байгууллагууд нь 1484.6 га-д тусгаарлалтын ажлыг хийж 15 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан 11141 м3 мод бэлтгээд байна. Орхон аймгийн иргэдийг түлшний модоор хяналттай хангаж байх зорилгоор Орхон аймагт Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон сумдаас модны зах байгуулж, Бугат сумын Санбэл ХХК –д 1500000 төгрөгний зээл ЖДҮ-ийг дэмжих сангаас олгож зах байгуулах үйл ажиллагаанд зарцуулаад байна. Мөн Орхон сум түлшний модныхоо захын Орхон аймгийн Их залуу багт байгуулан үйл ажиллагаа явуулаад байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймаг, сум орон нутагт шинээр ашиглалтад орж буй орон сууцнаас тодорхой тооны сууцыг хараагүй иргэдэд хуваарилан олгох, хараагүй хүнд зориулсан дэд бүтэц байгуулах асуудлыг хот төлөвлөлт, зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар судалж шийдвэрлэх ажлыг зохион байгуулж байна. Шинээр барьж байгаа барилгад газар олгохдоо хараагүй хүнд зориулсан дэд бүтэц / зам / байгуулан ажиллаж талаар гэрээ байгуулж ажиллаж байна.

/Хэрэгжилт 85,0 хувь/

2010 оноос эхлэн Булган аймаг малын индексжүүлсэн даатгал төсөлд хамрагдах болсон тул 2009 онд төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч, менежерийг сонгон шалгаруулж ажлын албан өрөөгөөр хангалаа. Сумд хадлан бэлтгэх талбай, болон бэлчээрийг хуваарьтай ашиглах малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулж сумдын Засаг даргын захирамж гаргаад байна. Хадлан бэлтгэх бололцоогүй урд бүсийн сумдыг малчдаас захилага авч нэгтгэх, сумын мал хамгаалах санд өвс тэжээл нөөцлөх талаар мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөн тусгаж сумдын Засаг дарга нарт даалгаж ажиллаа. Үүний дүнд аймгийн хэмжээнд 83,7 мянган тн хадлан бэлтгэсэн сан.

/ Хэрэгжилт 100 хувь/

Бэлчээрийн хортон мэрэгчид болон үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг Бүрэгхангай, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Баяннуур сумдад 20 мянган га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хүлээн авлаа.

/ Хэрэгжилт 100,0

хувь/

ХЯБХХН, Тогтвортой амьжиргаа-2 төслийн БМААЭУ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бэлчээрийн зохицуулалтын тогтолцоо бий болгох ажилууд хийгдэж эхлээд байна. Бэлчээрийн менежментийн асуудлыг зохицуулах төрийн бус байгууллага сумдад байгуулагдлаа. ТАТ-2 төслийн шугамаар Бүрэгхангай сумыг загвар сум болгохоор сонгоод байна аймгийн бэлчээрийн менежментийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж байна

/ Хэрэгжилт 80,0 хувь/

Ойн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн “Дэд хөтөлбөр”-ийг I, II шаттайгаар ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна. Хяганат тосгонд сум дундын ойн ангийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулаад байна. Ой хээрийн түймрээс хамгаалах төлөвлөгөө батлуулж, жил бүрийн 4-6 дугаар сард 120-140 морин эргүүл ажиллуулдаг болсон. МӨөн түймрээс урьдчилан сэргийлэх ажлаар сумдыг байр эзлүүлэн шагнадаг, хариуцлага тооцдог тогтолцоо бий болсон. Аймгийн ИТХ-аар модны жишиг үнийг тогтоолгон айл өрх албан газруудыг тарьц, суулгацаар хангаж, нийт 20658 ширхэг модыг шинээр тарьсны дээр 2714.65 м2 газрыг зүлэгжүүлж 2 сая, 560,0 мянган төгрөг зарцуулан арчилан хамгаалж байна. Энэ онд 969.4 га талбайг ойжуулж нөхөн сэргээгээд байна. 2010 оны ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлын бэлтгэлд аж ахуй нэгж байгууллагууд нь нийт 945000 ширхэг тарьц, 35000 ширхэг суулгац, 25 кг үрийг бэлтгэсэн. "Ашиглагч нь хамгаалагч байя" III зөвөлгөөнийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулан зохион байгуулж, мод бэлтгэлийн ажлыг мод бэлтгэгч эрх бүхий 3 аж ахуйн нэгжээр хийлгэж Бусад аж ахуйн нэгжүүдийг эдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зөвхөн зүсмэл үйлдвэрлэхээр зохион байгуулалт хийсэн болно. Мод бэлтгэгч аж ахуй нэгж байгууллагууд нь 1484.6 га-д тусгаарлалтын ажлыг хийж 15 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан 11141 м3 мод бэлтгээд байна.

Орхон аймгийн иргэдийг түлшний модоор хяналттай хангаж байх зорилгоор Орхон аймагт Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон сумдаас модны зах байгуулж, Бугат сумын Санбэл ХХК –д 1500000 төгрөгний зээл ЖДҮ-ийг дэмжих сангаас олгож зах байгуулах үйл ажиллагаандаа зарцуулаад байна. Мөн Орхон сум түлшний модныхоо захын Орхон аймгийн Их залуу багт байгуулан үйл ажиллагаа явуулаад байна.

/Хэрэгжилт 100.0 хувь/

Аймаг, сум орон нутагт Орон гэргүй, хараагүй иргэдэд газар хуваарилж олгох, шинээр ашиглалтад орж байгаа орон сууцны тодорхой хувийг тахир дутуу иргэдэд хуваарилдаг журам тогтоох асуудлыг судалж байна. Шинээр барьж орон сууцны барилгын газрыг олгохдоо хараагүй иргэдийг орон сууцтай болгох талаар гэрээ байгуулан ажиллаж гэр оронгүй хараагүй иргэдэд гэр олгох ажлуудыг үе шаттайгаар шийдвэрлэж байна.

/Хэрэгжилт 80,0 хувь/

Санхүү эдийн засгийн хүнрэлтэй холбогдуулан УИХ хурал 2009 оны төсвийг бууруулж тодотгосон, Мөн өр үүсгэж ажиллахгүй байх зорилгоор тухайн батлагдсан төсөвтөө багтаан зардал хооронд гүйлгэн шилжүүлэх эрх олгосон. Зарим сумд орон нутгийн оны эхний үлдэгдлийг сумын ИТХ-аараа хэлэлцүүлэн 81,6 сая төгрөгийг нэмж баталсан нь орон нутгийн төсвийн байгууллагуудын хувьд өргүй гарах тооцоо гарсан. Улсын төсвийн зарим байгууллагын хувьд халаалт, цэвэр бохир усны өртэй гарахаар байна.

/Хэрэгжилт-90,0 х увь/

Дунд сургуулийн сурагчдын хүйсийн харьцаанд жил бүр дүгнэлт хийн ажиллаж байна. Сурагчдын хүйсийн харьцаа бага, суурь боловсролд тэнцүү, харин ахлах ангид охидын эзлэх хувь 5-6 хувь илүү байна. Энэ талаар сургуулийн захирал, эцэг эхчүүдэд танилцуулсан.

/Хэрэгжилт 90 хувь /

Тэшиг сумын Бага-Илэнх боомтыг байнгын ажиллагаатай болгох талаар холбогдох газаруудад удаа дараа санал хүсэлт тавьж ажилласан ба 2009 оны 11 дүгээр сард 1 удаа нээж мал гаргасан байна.

/Хэрэгжилт 70,0 хувь/

Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002-2010 он/-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан ажлыг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган "Хүүхдийн хөгжил хамгаалалыг сайжруулах үндсэн чиглэл"-ийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан хэргжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна.

/Хэрэгжилт 90.0 хувь/

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад оруулах замаар хэрэгжүүлж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг 12 сум, 20 гаруй байгууллагад шалгаж дүгнэлт хийж, Хуульчдын зөвлөх баг томилон ажиллуулж байна.

“Хүүхдэд мэдрэмжтэй өмгөөлөл-хамгаалал” зөвлөгөөн-сургалтыг зохион байгуулж, хүүхдийн асуудлаар 8 илтгэл хэлэлцэж, зөвлөмж гаргалаа.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийн 20 жилийн ойг угтаж олон хэлбэрийн ажил зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүллээ.

Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах 2009-2012 оны үндсэн чиглэлийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн аймгийн ИТХТ-ийн хурлаар батлууллаа.

Хүүхдийн зуслангийн менежмент-бүтэц зохион байгуулалтыг өөрчилж, ХТХ-ийн удирдлагад шилжүүллээ.

Хүнд нөхцөл дэхь хүүхдийн судалгааг шинэчлэн гаргалаа.

Булган сум “хүүхдийн хүмүүжилд олон нийтийн оролцоо” зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Хэрэгжилт 100.0 хувь

Иргэдээс төрийн байгууллагад, албан тушалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган биелүүлж ажиллаж байгаа бөгөөд хэнд хэрхэн хандах арга замыг нээлттэй байлгах үүднээс аймгийн Засаг даргын Тамгын газрын нээлттэй ил тод байдлыг иргэдэд үзүүлэх самбарт өргөдөл гомдлыг хүлээн авах ажилтны дэлгэрэнгүй танилцуулгыг байрлуулж ажиллаа

/Хэрэгжилт 100,0 хувь/

Аймгийн ЗДТГ, БСГ, МХГ хамтран аймгийн нутаг дэвсгэрт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалтанд шалгалт хийж дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэн цаашид авах арга хэмжээний талаар тогтоол гаргууллаа. Нийт 105 түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг ойролцоо нутагладаг иргэдэд хариуцуулаад байна.

Хэрэгжилт 100 хувь

Хонины цэцэг өвчний голомт дээр хорио цээр хязгаарлалтын дэглэмийг сахиулах арга хэмжээ зохион байгуулах, халдварт өвчин илэрсэн үед болон гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож ажиллаа. манай аймгийн хувьд хонины цэцэг өвчин гараагүй. / **хэрэгжилт 100 хувь**/

Энэ онд улсын болон орон нутгийн төсөв хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэл үйлчилгээ хөгжүүлэхэд 4,0 тэр бум гаруй төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж 4 томоохон үйлдвэр 10 гаруй жижиг цех шинээр ашиглалтанд орж 170 гаруй ажлын байр бий боллоо. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд 170 гаруй төсөл ирүүлсэнийг төсөл шалгаруулах дэд комиссын хурлаар хэлэлцэж 87 төсөлд 893,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олголоо. **Хэрэгжилт -100 хувь**

Малын удмын санг хамгаалах чиглэлээр хангай хонь, сэлэнгэ үүлдрийн үхрийн цөм сүрэг үржлийн төвүүдийг нэгтгэж малын удмын санг хамгаалж цаашид өсгөн бойжуулах тоо толгойг нэмэгдүүлэх, өндөр ашиг шимтэй малын нийт малд эзлэх хувийн жин өсгөх цөм сүрэг үржлийн төвөөс хээлтүүлэгч хээлтэгчийг иргэдэд худалдан борлуулж ичмэл үр бэлдэж байна. мөн мал сүрэгт үзлэг ангилалт явуулж ашиг шим өндөртэй малыг гэрчилгээжүүлж, Бугат, Бүрэгхангай, Могод, Сэлэнгэ, Тэшиг, Хутаг-Өндөр сумдын 76501 хонь, 38213 ямаа нийт 114.7 мян бог малд ангилалт хийж, 8.0 мян хонь, 3.2 мян ямаагаар цөм сүрэг бүрдүүллээ. Эрүүл мэндийг хамгаалахад Европын холбооноос хэрэгжиж байгаа “Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээл” төслийг хэрэгжүүлж байна. арьс шир түүхий эдийн чанарыг сайжруулахад Мал эмнэлэг үржлийн нэгжийг 43 болгон нэмэгдүүлж энэ чиглэлийн ажил үйлчилгээг хэрэглэгчдэд ойртуулах арга хэмжээг зохион байгуулж, шинээр анхан шатны ажил үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгжүүдийг дэмжиж багаж тоног төхөөрөмжөөр ханган зээлийн өрсөлдөөнийг бий болгож байна. /**Хэрэгжилт 100 хувь**/

Нийтэд ил тод мэдээлэх самбарт аливаа төлбөр хурамж авч ажиллах албан хаагч түүний тарифыг бичсэн самбар байрлуулсан бөгөөд аймгийн хэмжээнд улсын бүртгэлийн хэлтэс, архивын алба зэрэг байгууллагууд ил тод байдлыг хангаж ажиллаж байна **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Хууль бусаар төлбөр хураамж авсан эсэх гомдол мэдээллийг авах чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын үүдэнд саналын хайрцаг ажиллуулж байгаа бөгөөд энэ талаар амаар болон бичгээр өгөх шаардлага гарвал хэнд хандах талаар нээлттэй байдлыг хангасан самбарт тухайн албан тушаалтны мэдээллийг байрлуулан ажиллаж байна **/Хэрэгжилт нь 100 хувь/**

Сангийн сайдын 2006 оны 55 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn сайтад тендерийн урилга, үр дүнг бүр тухай бүр тавьж нийтэд мэдээлж байна.

/Хэрэгжилт нь 100 хувь/

Аймгийн хэмжээнд зочид буудлын стандартын шаардлагад нийцсэн 3 цэг үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд стандартын шаардлага хангасан саун массаж барьцаалан зээлдүүлэх газар үйл ажиллагаа явуулаагүй байна. **Хэрэгжилт - 50,0 хувь**

2008 оны тайланг улс орон нутгийн төсвийн байгууллагаар гарган нэгтгэж сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн. 2009 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэн Сангийн яам болон удирдлагад мэдээлж байна.

/Хэрэгжилт 100,0 хувь/

Орон нутагт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдон СТСХ-т хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр бий болгосон. Ингэснээр хөрөнгө оруулалтын арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих, нэгтгэх, тайлагнах зэрэг ажлууд тодорхой ахиц дэвшил гарч байна. МУ-ыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажилд тасарсан болон хоцорсон ажил байхгүй болно.

/Хэрэгжилт 90 хувь/

Одоогоор аймгийн хэмжээнд хувиараа ашигт малтмал олборлодог иргэд бүртгэгдээгүй бөгөөд Дашинчилэн суманд хууль бусаар алт олборлодог иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчлийг арилгуулах талаар 2 удаа албан шаардлага өгөөд байна

Хэрэгжилт 100,0 хувь

Тэшиг сумын мөнгөн усаар бохирдсон хөрсийг булж дарах, хоргүйжүүлэх арга хэмжээ авсан бөгөөд цаашид химийн хорт бодисын хууль бус хэрэглээг таслан зогсоох, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх талаар сумдын удирдлага болон холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн.

Хэрэгжилт 100,0 хувь

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч төрийн захиргааны жинхэнэ албан хаагч байхгүй бөгөөд энэ талаар сум байгууллагад үүрэг чиглэл өгч аймгийн ИТХ-тай хамтарч ажиллаж байна. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

2007, 2008 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дуусаагүй барилга байгууламжийн талаархи судалгааг хийж холбогдох мэргэжлийн байгууллагуудын тооцоо болон судалгаа дүгнэлтийг үндэслэн тооцоо судалгааг Булган аймгийн Татварын хэлтсийн конторын барилга, Булган аймгийн Рашаант сумын хүн эмнэлгийн өргөтгөлийн барилга, Булган аймгийн төвд баригдах Спорт цогцолборын барилга зэрэг объектуудаар гарган хүргүүлэн алданги тооцон ажилласан. **/Хэрэгжилт 100,0 хувь/**

Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилн сэргийлэх чиглэлээр баг хот айл бүрт хүргэх мэдээллийн шуурхай байдлыг хангах арга хэмжээ авахыг сумдад даалгасаны дүнд ихэнх сумууд багтаа мэдээллийн сүлжээ гэсэн график бий болгож ажиллаа. Үүний дүнд аливаа мэдээ мэдээлэл шуурхай хүргэж ажиллаж байна./Хэрэгжилт 100,0 хувь/

Төр, төсвийн байгууллагуудын ажилтнуудыг зуны улирал болон хэт халуун байгаа нөхцөлд зангиагүй байх бусад дипломат арга хэмжээ ёслол хүндэтгэлийн үед ёслолын хувцас өмсөж байхыг зөвшөөрсөн албан бичгийг сум, агентлаг байгууллагуудад хүргүүлээд байна. /Хэрэгжилт 100,0 хувь/

Ямарваа арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг эрчимжүүлэх хөрөнгийн асуудлыг орон нутгийн төсөвт тусгасан бөгөөд 2010 онд нийт 4 агентлаг 4 сумдад хяналт шинжилгээ хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна. /Хэрэгжилт 100,0 хувь/

ХХААХҮ- ийн сайдын 02 албан даалгаврын дагуу төсөл шалгаруулах дэд комиссыг аймгийн Засаг дарга 2009 оны 258 тоот захирамжаар томилж, орон нутаг дахь Хас банктай харилцан тохиролцож хамтран ажиллах гэрээ байгуулж 903,5 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж 87 үйлдвэрлэл эрхлэгчдэд орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн дагуу 100,0 хувь зээлдүүлээ. /Хэрэгжилт -100,0 хувь /

Шинэ жилийн баяр аливаа бусад арга хэмжээнд төсвөөс хөрөнгө мөнгө гаргахгүй байхыг бүх төсвийн ерөнхий менежерүүдэд үүрэг чиглэл өгсөн бөгөөд үүссэн өрийг барагдуулах арга хэмжээг авч ажиллахыг даалгалаа. **/Хэрэгжилт 50,0 хувь/**

Аймгийн Засаг даргад салбарын яамдуудаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийг хугацаанд нь хуулийн дагуу чанартай зохион байгуулж ажиллалаа. 2009 онд нийт 2,3 тэрбум төгрөгийн 16 нэр төрлийн төсөл арга хэмжээ шилжиж ирсэн бөгөөд дээрхи ажлуудын гүйцэтгэгчийг шалгаруулан ихэнхи ажлыг улсын болон техникийн комиссоор эцэслэн хүлээж аваад байна. Зарим төрлийн ажил 2010 онд үргэлжлэхээр хүлээгдэж байна. **/Хүлээгдэж байгаа/**

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын 370 тоот тушаалыг төсвийн байгууллагын ерөнхийлөн захирагч нарт сурталчлан ажиллалаа.Томуугийн А хүрээний /H1N1 / вирусийн өвчлөлийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулан явуулж, энэ хугацаанд жирэмсэн эхчүүдийн хяналтанд онцгой анхаарал тавин ажиллаж, жирэмсэн эхчүүдэд цалинтай чөлөө олгосон.Жирэмсэн эхчүүдийг өрхийн эмнэлэг, эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх газар хамтран хянаж байна. **Хэрэгжилт 90.0%**

Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2009 оны 3-р улирлын хэрэгжилтийн явцын тухай танилцуулсан танилцуулгын дагуу аймагт удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэжмээ авч ажиллахыг холбогдох агентлаг, хэлтэст үүрэг чиглэл өгч ажилласан бөгөөд цаг хугацааны хувьд шинээр ирсэн тогтоолууд удаашралтай байгаа байдал ажиглагдаж байна. **/Хрэгжилт 90 хувь/**

